



СӨБ-Н 3-5 НАСНЫ
ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН
СУДАЛГАА

(ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

АГУУЛГА

Зургийн жагсаалт.....	3
Хүснэгтийн жагсаалт	5
Нэг. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ	7
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	7
1.1 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ ...	16
1.1.1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ӨСӨЛТ/ЕРӨНХИЙ ХӨГЖИЛ	16
Толгойн тойрог	22
Биеийн жин	22
Биеийн өндөр.....	22
Цээжний тойрог	23
Бүсэлхийн тойрог.....	23
1.1.2 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН БЭЛТГЭЛЖИЛТ	23
Дүгнэлт	32
1.2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН ТАНИН МЭДЭХҮЙН ХӨГЖИЛ	33
1.2.1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭЖ АВАХ ЧАДВАР (АНХААРАЛ, ХҮРТЭХҮЙ, ОЙ ТОГТООЛТ)	33
1.2.2.СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН СЭТГЭХҮЙ, ХЭЛ ЯРИАНЫ ЧАДВАР	37
1.3 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН НИЙГЭМШИЛ	46
1.3.1 Сургуулийн өмнөх боловсролын 3-5 насны хүүхдийн өөрийн тухай ойлголт.....	46
Хүүхдийн “өөрийн тухай ойлголт”	46
Хөгжүүлэх гол чиглэлүүд	46
1.3.2 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨН, ХАРИЛЦАА /ХЭМ ХЭМЖЭЭ/.....	50
1.4. ДҮГНЭЛТ	62
Хүүхдийн амьдралын орчин.....	62
Эцэг эхийн ажил эрхлэлт ба боловсрол	62
Өрхийн орлого.....	62
Хөдөлгөөн, дүрэм журам, дадал зуршил	62
Танин мэдэхүйн хөгжлийн нэгдсэн дүгнэлт.....	63
Мэдээлэл хүлээн авах чадвар	63
Сэтгэхүй	63
Хэл ярианы чадвар	63
Нийгэмшлийн чадварын нэгдсэн дүгнэлт.....	63

Өөрийгөө танин мэдэх, илэрхийлэх чадвар	63
Сэтгэл хөдлөлийг таних, илэрхийлэх, зохицуулах чадвар	64
Харилцааны чадвар	64
Тусламж хүсэх, нийгмийн орчинд хариу үйлдэл үзүүлэх чадвар	64
Дүрэм журам баримтлах ойлголт.....	64
Биеийн өсөлт ба бүс нутгийн ялгаа	64
Насны онцлог ба өсөлтийн хурдац.....	64
3. Бие бялдрын чадваруудын төлөв	65
СӨБ-ын хөтөлбөртэй уялдаа.....	65

Зургийн жагсаалт

Зураг 1. Хүүхдийн талаар мэдээлэл өгсөн хүн, судалгаа 2	Зураг 2. Хүүхдийн талаар мэдээлэл өгсөн хүн, судалгаа 3	Error! Bookmark not defined.
Зураг 3. Хүүхдийн цэцэрлэгт хамрагдсан жил Судалгаа 1 ба Судалгаа 2		7
Зураг 4. Хүүхдийн амьдарч буй өрхийн сарын орлого (Судалгаа 1 ба Судалгаа 2)		10
Зураг 5. Үлгэр уншиж, ярьж өгдөг эсэх		11
Зураг 6. Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны оролцоо		12
Зураг 7. Толгойн тойрог насаар		17
Зураг 8. Толгойн тойрог охид бүсээр		17
Зураг 9. Толгойн тойрог хөвгүүд		17
Зураг 10. Биеийн жин насаар		18
Зураг 11. Охидын биеийн жин бүсээр		18
Зураг 12. Хөвгүүдийн биеийн жин бүсээр		18
Зураг 13. Судалгаа 1 ба 2 биеийн жингийн харьцуулсан үзүүлэлт		18
Зураг 14. Биеийн өндөр насаар		19
Зураг 15. Охидын биеийн өндрийн үзүүлэлт бүсээр		19
Зураг 16. Хөвгүүдийн биеийн өндрийн үзүүлэлт бүсээр		19
Зураг 17. Судалгаа 1 ба 2 биеийн өндрийн харьцуулсан үзүүлэлт		20
Зураг 18. Бүсэлхийн тойрог насаар		20
Зураг 19. Цээжний тойрог насаар		20
Зураг 20. Хөвгүүдийн цээжний тойрог бүсээр		20
Зураг 21. Судалгаа 1 ба 2 цээжний тойрог		21
Зураг 22. Охидын бүсэлхийн тойрог бүсээр		21
Зураг 23. Охидын бүсэлхийн тойрог бүсээр		21
Зураг 24. Хөвгүүдийн бүсэлхийн тойрог бүсээр		22
Зураг 25. Судалгаа 1 ба 2 бүсэлхийн тойрог		22
Зураг 26. Хурдны чадварын үзүүлэлт(сек)		24
Зураг 28. Охидын хурдны чадварын үзүүлэлт бүсээр (сек)		24
Зураг 28. Хөвгүүдийн хурдны чадварын үзүүлэлт бүсээр(сек)		25
Зураг 30. Судалгаа 1 ба 2 харьцуулалт хурдны чадвар (сек)		25
Зураг 30. Уян хатан чадварын үзүүлэлт(ст)		26
Зураг 31. Охидын уян хатан чадвар бүсээр(ст)		26
Зураг 32. Хөвгүүдийн уян хатан чадвар бүсээр(ст)		27
Зураг 33. Судалгаа 1 ба 2 уян хатан чадвар		27
Зураг 34. Авхаалж самбаатай чадварын үзүүлэлт		27
Зураг 35. Тэнцвэрийн чадвар үзүүлэлт (сек)		28
Зураг 36. Охидын тэнцвэрийн чадвар бүсээр(сек)		28
Зураг 38. Хөвгүүдийн тэнцвэрийн чадвар бүсээр (сек)		28
Зураг 38. Судалгаа 1 ба 2 тэнцвэрийн чадвар (сек)		28
Зураг 39. Хөлийн хүчний чадвар (ст)		29
Зураг 40. Охидын хөлийн хүчний чадвар бүсээр (ст)		29
Зураг 41. Хөвгүүдийн хөлийн хүчний чадвар бүсээр (ст)		29
Зураг 42. Судалгаа 1 ба Судалгаа 2 хөлийн хүчний чадварын үзүүлэлт (ст)		30
Зураг 43. Тэсвэрийн чадварын үзүүлэлт насаар (сек)		30
Зураг 45. Охидын тэсвэрийн чадвар(сек)		30
Зураг 45. Хөвгүүдийн тэсвэрийн чадвар бүсээр(сек)		31
Зураг 46. Хүүхдийн юмсыг ажиглах чадварын түвшин		34
Зураг 48. Хүүхдийн юмсыг ажиглах чадвар зураг тус бүрээр		34

Зураг 49. Сонсож тогтоох чадвар	35
Зураг 50. Сонорын ой тогтоолт	36
Зураг 51. Нийт насаар сонорын ой тогтоолт	36
Зураг 52. Анхаарлын тогтворжилт гүйцэтгэл насаар	37
Зураг 53. Логиктой сэтгэх чадвар	38
Зураг 54. Сэтгэхүйн харьцуулан ангилах чадварын гүйцэтгэл насаар	39
Зураг 55. Сэтгэхүйн харьцуулах, нэгтгэн дүгнэх чадвар	40
Зураг 56. Хэл ярианы чадвар санаагаа 1-2 өгүүлбэрээр илэрхийлсэн байдал	40
Зураг 57. Хэл ярианы чадвар санаагаа 3-4 өгүүлбэрээр илэрхийлсэн байдал	41
Зураг 58. Хэл ярианы чадвар санаагаа 5 дээш өгүүлбэрээр илэрхийлсэн байдал	41
Зураг 59. Санаагаа илэрхийлсэн хугацаа	41
Зураг 60. Санаагаа өгүүлбэрээр илэрхийлсэн байдал Судалгаа 1 ба судалгаа 2	42
Зураг 61. Хүүхдийн идэвхтэй үгийн нөөц	42
Зураг 62. Өөрийн тухай ойлголт 3 настай хүүхдүүд бүсээр	49
Зураг 63. Өөрийн тухай ойлголт 4 настай хүүхдүүд бүсээр	49
Зураг 64. Өөрийн тухай ойлголт 5 настай хүүхдүүд бүсээр	50
Зураг 65. Өөрийн сэтгэл хөдлөл илэрхийлэх байдал (3 нас, бүсээр)	51
Зураг 66. Өөрийн сэтгэл хөдлөл илэрхийлэх байдал (4 нас, бүсээр)	51
Зураг 67. Өөрийн сэтгэл хөдлөл илэрхийлэх байдал (5 нас, бүсээр)	52
Зураг 68. Бусдын сэтгэл хөдлөлийг таних байдал (3 нас, бүсээр)	52
Зураг 69. Үе тэнгийнхэнтэйгээ хамтран тоглох (3 нас, бүсээр)	54
Зураг 70. Үе тэнгийнхэнтэйгээ хамтран тоглох (4 нас, бүсээр)	55
Зураг 71. Үе тэнгийнхэнтэйгээ хамтран тоглох (5 нас, бүсээр)	55
Зураг 72. Бусдаас дэмжлэг авах чадвар (3 нас, бүсээр)	56
Зураг 73. Бусдаас дэмжлэг авах чадвар (4 нас, бүсээр)	56
Зураг 74. Бусдаас дэмжлэг авах чадвар (5 нас, бүсээр)	57
Зураг 75. Дүрэм журам баримтлах чадвар (3 нас, бүсээр)	58
Зураг 76. Дүрэм журам баримтлах чадвар (4 нас, бүсээр)	58
Зураг 77. Дүрэм журам баримтлах чадвар (5 нас, бүсээр)	58

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Цэцэрлэгт хамрагдсан жил.....	7
Хүснэгт 2. Хүүхдийн амьдарч буй өрхийн гишүүдийн тоо (хувь).....	7
Хүснэгт 3. хүүхдийн гэрээс цэцэрлэг хүрэх зай бүсээр	7
Хүснэгт 4. хүүхдийн амьдарч буй газар (хувь)	8
Хүснэгт 5. Аавын боловсролын түвшин бүсээр	8
Хүснэгт 6. Аавын хөдөлмөр эрхлэлт бүсээр	8
Хүснэгт 7. Ээжийн боловсролын түвшин бүсээр.....	9
Хүснэгт 8. Ээжийн хөдөлмөр эрхлэлт бүсээр.....	9
Хүснэгт 9. Хүүхдийн эцэг, эхийн боловсролын түвшин.....	9
Хүснэгт 10. Хүүхдийн эцэг, эхийн ажил эрхлэлт.....	10
Хүснэгт 11. Хүүхдийн амьдарч буй өрхийн сарын орлого бүсээр.....	10
Хүснэгт 12. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдээ үлгэр уншиж өгдөг эсэх.....	11
Хүснэгт 13. Үлгэр, ном уншиж өгдөг эсэх бүхээр.....	11
Хүснэгт 14. Хүүхдийн оролцоо эцэг эх асран хамгаалагчдын хариултаар бүсээр.....	12
Хүснэгт 15. Хүүхдийн чадваруудыг эцэг эх, асран хамгаалагчид үнэлсэн байдал.....	12
Хүснэгт 16. Хүүхдийн хөдөлгөөн, тэнцвэр, дүрэм баримтлах, аюул тохиолдсон үед бусдаас тусламж авах чадваруудыг эцэг эх, асран хамгаалагчид үнэлсэн байдал.	13
Хүснэгт 17.Хүүхдийн хэл яриа, сэтгэлийн хөдөлгөөн нийгэмшлийн чадваруудын талаарх эцэг эх, асран хамгаалагчид үнэлсэн байдал.....	13
Хүснэгт 18. Хүүхдийн хөгжлийн талаарх эцэг эх, асран хамгаалагчид үнэлсэн байдал	13
Хүснэгт 19. Бие бялдрын өсөлтийн статистик үзүүлэлт	16
Хүснэгт 20. Бие бялдрын бэлтгэлжилтийн чадваруудын статистик үзүүлэлт (4 нас хөвгүүд).....	23
Хүснэгт 21. Хурдны чадварын бүсийн үзүүлэлт насаар	25
Хүснэгт 22. Тэнцвэрийн чадварын харьцуулсан үзүүлэлт.....	29
Хүснэгт 23.Хүүхдийн биеийн хөгжлийн үзүүлэлт ба хамаарал	31
Хүснэгт 24. Бэлтгэлжилтийн чадвар ба үндсэн мэдээлэл.....	31
Хүснэгт 25.Бие бялдрын чадварууд ба танин мэдэхүйн хамаарал	31
Хүснэгт 26. Мэдээллийг хүлээн авах чадваруудын статистик үзүүлэлт	33
Хүснэгт 27.Чадваруудын дундаж үзүүлэлт.....	33
Хүснэгт 28. Юмсыг ажиглах чадвар нас ба бүсээр	35
Хүснэгт 29. Сонсоод тогтоох чадварын гүйцэтгэл, нас бүсээр	36
Хүснэгт 30. Анхааралын тогтворжилт бүсээр.....	37
Хүснэгт 31.Логиктой сэтгэх чадварын статистик үзүүлэлт	37
Хүснэгт 32.Сэтгэхүй ба хэл ярианы статистик үзүүлэлт.....	38
Хүснэгт 33.Логиктой сэтгэх чадвар бүс, насаар.....	39
Хүснэгт 34. Сэтгэхүйн харьцуулан ангилах чадварын гүйцэтгэл бүс, насаар	39
Хүснэгт 35.Сэтгэхүйн харьцуулах нэгтгэн дүгнэх чадвар	40
Хүснэгт 36.Санаагаа илэрхийлсэн үгийн тоо.....	42
Хүснэгт 37. Өөрийн тухай ойлголт - Өөрийн нэрийг мэддэг байдал, насаар (3-5 нас, хувь).....	47
Хүснэгт 38. Өөрийн насаа мэддэг эсэх, хувиар (3-5 нас)	47
Хүснэгт 39. Өөрийн хүйсээ мэддэг эсэх, насаар (3-5 нас).....	48
Хүснэгт 40. Аавынхаа нэрийг мэддэг эсэх, хувиар (3-5 нас)	48
Хүснэгт 41. Ээжийнхээ нэрийг мэддэг эсэх, хувиар (3-5 нас).....	48
Хүснэгт 42. Ам бүлийн тоог хэлсэн байдал, хувиар (3-5 нас)	48
Хүснэгт 43. Суралцдаг бүлэг нэрлэсэн эсэх, хувиар (3-5 нас).....	49
Хүснэгт 44. Сэтгэлийн хөдөлгөөнөө мэдэх, хувиар (3-5 нас).....	50
Хүснэгт 45. Сөрөг сэтгэлийн хөдөлгөөнөө мэдэх, хувиар (3-5 нас).....	51

Хүснэгт 46. Найзтай эсэх талаарх асуултын хариулт.....	54
Хүснэгт 47. Найзуудтайгаа тоголдог, хэрхэн тоглодог талаар (3-5 нас).....	54
Хүснэгт 48. Хүүхэд тоглоомоо хуваалцах байдал (3-5 нас).....	54
Хүснэгт 49. Аюул тохиолдсон үед бусдаас тусламж, дэмжлэг авах чадвар (3-5 нас).....	55
Хүснэгт 50. Өөрт хэрэгтэй зүйл авах үед бусдаас тусламж, дэмжлэг авах чадвар (3-5 нас).....	56
Хүснэгт 51. Дүрэм, журам баримтлах чадвар (3-5 нас).....	57
Хүснэгт 52. Олон нийтийн газар дүрэм журам баримтлах чадвар (3-5 нас).....	57
Хүснэгт 53. Өөрийн тухай ойлголтуудын хамаарал.....	59

НЭГ. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаанд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 4 цэцэрлэг, Их-Уул, Рэнчинлүмбэ, Цэцэрлэг, Шинэ-Идэр сумын 3-5 настай нийт 390 хүүхэд оролцсон. Судалгаанд хамрагдсан хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдаас асуулга судалгаа авсан. Судалгаанд 60.3 хувь нь ээж, 21.8 хувь нь аав, 17.8 хувь нь эмээ өвөө, ах эгч нь байсан байна. Хүйсийн хувьд харьцуулах боломжтой гэж үзэн тэнцвэртэй байхаар санамсаргүй түүврээр сонгосон болно.

Хүснэгт 1. Цэцэрлэгт хамрагдсан жил

	1 жил	2 жил	3 жил	4 жил
Судалгаа 1	11.1	29.2	38.2	21.5
Судалгаа 2	15.9	33.7	27.4	23.0

Хүүхдийн 15.9 хувь нь 1 жил, 33.7 хувь нь 2 дахь жилдээ, 27.4 хувь нь 3 дахь жилдээ, 23.0 хувь нь 4 дэх жилдээ СӨБ -д хамрагдаж байна. Судалгаанд хамрагдсан хүүхдийн 1, 2 ба 4 жилийн хувь нэмэгдсэн ч 3 дахь жилдээ суралцаж байгаа хүүхдийн хувь 10.8 хувиар бага байна.

Хүснэгт 2. Хүүхдийн амьдарч буй өрхийн гишүүдийн тоо (хувь)

Гишүүдийн тоо	2	3	4	5	6	7	8	9 болон түүнээс дээш
Судалгаа 1	0.7	18.8	37.5	27.8	10.4	4.2	0.0	0.7
Судалгаа 2	2.4	13.5	33.3	29.8	15.1	4.8	0.4	0.8

Судалгаанд хамрагдсан хүүхдийн 15.9 хувь нь 2-3 гишүүнтэй өрхөд, 63.0 хувь нь 4-5 гишүүнтэй өрхөд, 21.0 хувь нь 6-9 гишүүнтэй өрхөд амьдардаг байна. Хүүхдийн 88.9 хувь нь гэртээ, 11.1 хувь нь эмээ өвөөгийн дөө амьдарч байна.


Хүснэгт 3. хүүхдийн гэрээс цэцэрлэг хүрэх зай бүсээр

Зай	Төвийн бүс	Хойд бүс	Баруун бүс	Урд бүс	Зүүн бүс	Нийт
500м-1км	40.7	44.4	66.7	58.3	50.0	48.8
1км-2км	29.6	33.3	19.4	22.2	30.6	27.8
2км-3км	11.1	11.1	8.3	8.3	11.1	10.3
3км-4км	10.2	5.6	2.8	8.3	2.8	7.1
4км-5км	4.6	5.6	2.8	0.0	5.6	4.0
5км-ээс дээш	3.7	0.0	0.0	2.8	0.0	2.0

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдүүд ихэвчлэн гэрээсээ 500м -1 км хол зайд байрлах цэцэрлэгт хамрагддаг байна. Харин гэрээсээ 4 өөс дээш км-т байрлах цэцэрлэгт төвийн бүсийн хүүхдийн 8.3 хувь нь хамрагддаг байна.

Мөн 48.8 хувь нь цэцэрлэгээсээ 500-1 км зайтай газар амьдардаг, 38.1 хувь нь 1-3 км зайтай газар, 11.1 хувь нь 3- дээш км зайтай газар амьдарч байна.

Зураг 1. Хүүхдийн цэцэрлэгт хамрагдсан жил Судалгаа 1 ба Судалгаа 2



Хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж суралцах нь нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. хүүхдийн амьдарч буй газар (хувь)

Амьдардаг газар	Судалгаа 1	Судалгаа 2	Орон сууцанд амьдарч буй хувь болон түрээсийн байранд амьдрах хувь өссөн байна
Орон сууц	21.5	22.6	
Түрээсийн байр	0.0	1.2	
Гэр хороололд	78.5	76.2	

Хүснэгт 5. Аавын боловсролын түвшин бүсээр

Аавын боловсролын түвшин	Төвийн бүс	Хойд бүс	Баруун бүс	Урд бүс	Зүүн бүс	Нийт
Хариулаагүй	3.7	0.0	5.6	2.8	5.6	3.6
Боловсрол эзэмшээгүй	0.0	0.0	2.8	0.0	0.0	0.4
Бага	0.0	5.6	16.7	5.6	0.0	4.0
Суурь	1.9	5.6	5.6	2.8	2.8	3.2
Бүрэн дунд	42.6	69.4	36.1	47.2	47.2	46.8
Тусгай дунд	5.6	5.6	8.3	2.8	2.8	5.2
Дээд	46.3	13.9	25.0	38.9	41.7	36.9

Төвийн бүсэд амьдарч буй аавуудын 46.3 хувь, зүүн бүсийн 41.7 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байгаа бол хойд бүсийн аавуудын 69.4 хувь нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн байна.

Хүснэгт 6. Аавын хөдөлмөр эрхлэлт бүсээр

Аавын хөдөлмөр эрхлэлт	Төвийн бүс	Хойд бүс	Баруун бүс	Урд бүс	Зүүн бүс	Нийт
Төсвийн байгууллага	32.4	33.3	36.1	30.6	19.4	31.0
Хувийн хэвшил	21.3	8.3	11.1	11.1	22.2	16.7
Хувиараа жижиг бизнес	21.3	16.7	19.4	11.1	16.7	18.3
Малчин	12.0	27.8	25.0	33.3	30.6	21.8
Ажилгүй	1.9	2.8	0.0	5.6	2.8	2.4
Бусад	7.4	8.3	2.8	5.6	5.6	6.3
Хариулаагүй	3.7	2.8	5.6	2.8	2.8	3.6

Хойд бүсэд амьдарч буй аавуудын 32.4 хувь, хойд бүсийн аавуудын 33.3 хувь, баруун бүсэд амьдарч буй аавуудын 36.1 хувь нь төсвийн байгууллагад ажиллаж байгаа бол урд болон зүүн бүсэд амьдарч буй аавуудын 33.3-30.6 хувь нь малчин байна.

Хүснэгт 7. Ээжийн боловсролын түвшин бүсээр

Ээжийн боловсролын түвшин	Төвийн бүс	Хойд бүс	Баруун бүс	Урд бүс	Зүүн бүс	Нийт
Хариулаагүй	0.0	0.0	2.8	0.0	0.0	0.4
Бага	0.9	2.8	5.6	8.3	0.0	2.8
Суурь	0.0	5.6	0.0	0.0	2.8	1.2
Бүрэн дунд	29.6	52.8	36.1	36.1	38.9	36.1
Тусгай дунд	5.6	0.0	5.6	0.0	2.8	3.6
Дээд	63.9	38.9	50.0	55.6	55.6	56.0

Төвийн бүсэд амьдарч буй ээжүүдийн 63.9 хувь, урд болон зүүн бүсийн ээжүүдийн 55.6 хувь нь дээд боловсрол эзэмшсэн бол зүүн бүсийн ээжүүдийн 38.9 хувь, хойд бүсийн ээжүүдийн 52.8 хувь нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн байна.

Хүснэгт 8. Ээжийн хөдөлмөр эрхлэлт бүсээр

Ээжийн хөдөлмөр эрхлэлт	Төвийн бүс	Хойд бүс	Баруун бүс	Урд бүс	Зүүн бүс	Нийт
Төсвийн байгууллага	49.1	41.7	50.0	52.8	47.2	48.4
Хувийн хэвшил	19.4	11.1	5.6	13.9	5.6	13.5
Хувиараа жижиг бизнес	14.8	16.7	8.3	8.3	5.6	11.9
Малчин	6.5	25.0	22.2	19.4	27.8	16.3
Ажилгүй	8.3	0.0	13.9	2.8	11.1	7.5
Бусад	1.9	5.6	0.0	2.8	2.8	2.4

Зүүн болон хойд бүсэд амьдарч буй ээжүүдийн 25.0 - 27.8 хувь нь малчин бол баруун бүсэд амьдарч буй ээжүүдийн 13.9 хувь нь ажил эрхэлдэггүй гэж хариулсан байна.

Хүснэгт 9. Хүүхдийн эцэг, эхийн боловсролын түвшин

Боловсролын түвшин	Боловсрол эзэмшээгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд	Хариулаагүй
Эцгийн боловсрол	Судалгаа 1	2.1	6.3	4.2	47.2	6.3	1.4
	Судалгаа 2	0.4	4.0	3.2	46.8	5.2	3.6
Эхийн боловсрол	Судалгаа 1	1.4	4.9	0.0	28.5	5.6	0.0
	Судалгаа 2	0.0	2.8	1.2	36.1	3.6	0.4

Судалгаанд хамрагдсан хүүхдийн эцгийн боловсролын түвшинг судалгаа 1 ба 2 той харьцуулан авч үзэхэд дээд боловсрол эзэмшилт 2.2 хувь нэмэгдсэн, тусгай дунд боловсрол, суурь

боловсрол эзэмшилт 1 -1.1 хувь буурсан, боловсрол эзэмшээгүй байдал 1.7 хувь буурсан байна. Эхийн боловсролын хувьд бүрэн дунд боловсрол эзэмшилт 7.6 хувь нэмэгдсэн бол бага боловсрол, тусгай дунд боловсрол эзэмшсэн байдал буурсан тэр дундаа дээд боловсрол эзэмшилт 3.7 хувь буурсан байна. Хоёр дахь судалгаанд хамрагдсан хүүхдийн эцгийн 0.4 хувь боловсрол эзэмшээгүй, 7.2 хувь нь бага болон суурь боловсрол эзэмшсэн, 46.8 хувь нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 36.9 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна. Харин эхийн 56.0 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна.


Хүснэгт 10. Хүүхдийн эцэг, эхийн ажил эрхлэлт

Хөдөлмөр эрхлэлт	Төсвийн байгууллага	Хувийн хэвшил	Хувиараа жижиг бизнес	Малчин	Ажилгүй	Бусад	Хариулаагүй
Эцэг	Судалгаа 1	25.0	16.7	20.1	24.3	7.6	2.8
	Судалгаа 2	31.0	16.7	18.3	21.8	2.4	3.6
Эх	Судалгаа 1	43.8	12.5	16.0	14.6	11.1	0.0
	Судалгаа 2	48.4	13.5	11.9	16.3	7.5	0.0

Эцгийн ажил эрхлэлтийн хувьд төсвийн байгууллагад ажиллаж буй байдал 6.0 хувь нэмэгдсэн бол хувиараа жижиг бизнес эрхлэлт 1.8 хувь, малчин 2.5 хувь, ажилгүйдэл 5.2 хувь буурсан байгааг хариултаас харж болохоор байна. Эхийн хувьд төсвийн байгууллагад ажиллаж байгаа гэсэн хариулт 4.6 хувь нэмэгдсэн бол хувиараа жижиг бизнес эрхэлж буй байдал 4.1 хувь буурсан, ажилгүй гэсэн хариулт 3.6 хувиар буурсан нь ажил эрхлэлт бага зэрэг нэмэгдсэн байна гэж харж болохоор байна.

Хоёр дахь шатны судалгаанд хамрагдсан хүүхдийн хувьд ажил эрхлэлтийн хувьд эцгийн 2.4 хувь, эхийн 7.5 хувь ажил эрхлээгүй, эцгийн 21.8 хувь малчин, эхийн 48.4 хувь нь төсвийн байгууллагад ажилладаг гэж хариулсан байна.

Зураг 2. Хүүхдийн амьдарч буй өрхийн сарын орлого (Судалгаа 1 ба Судалгаа 2)




Хүүхдийн амьдарч буй өрхийн сарын орлого 5 жилийн өмнөх судалгааны үзүүлэлттэй харьцуулахад нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Хүүхдийн амьдарч буй өрхийн сарын орлого бүсээр

Өрхийн орлого	Төвийн бүс	Хойд бүс	Баруун бүс	Урд бүс	Зүүн бүс	Нийт
100 мянга хүртэл	0.0	8.3	16.7	5.6	2.8	4.8
101-300 мянга	2.8	0.0	5.6	0.0	2.8	2.4
301-500 мянга	4.6	8.3	2.8	13.9	8.3	6.7
501-700 мянга	5.6	2.8	2.8	0.0	2.8	3.6
701-900 мянга	9.3	11.1	2.8	13.9	13.9	9.9
901-1 сая 100 мянга	6.5	0.0	5.6	0.0	2.8	4.0
1 сая 101 мянга-1 сая 300 мянга	13.9	13.9	16.7	16.7	13.9	14.7
1 сая 301 мянга-1 сая 500 мянга	10.2	22.2	5.6	11.1	8.3	11.1
1 сая 501 мянгаас дээш	47.2	33.3	41.7	38.9	44.4	42.9

Хүүхдийн амьдарч буй өрхийн сарын орлогыг бүсээр авч үзэхэд 5 бүсийн өрхүүдийн 64.0-71.3 хувь нь 1 сая 101 мянгаас 1 сая 501 мянган төгрөгний орлоготой гэр бүлд амьдарч байна. Төвийн бүсийн хүүхдийн 71.3 хувь нь хамгийн өндөр орлоготой гэр бүлд амьдарч байна.

Зураг 3. Үлгэр уншиж, ярьж өгдөг эсэх



Хүүхдээ өдөр бүр насны онцлогт нь тохирсон үлгэр ном хамтран уншиж өгөх нь хөгжлийг нь дэмжих үйл ажиллагаа болох ба судалгаанд хамрагдсан хүүхдийн 90.1 хувь нь уншиж өгдөг гэсэн бол 9.9 хувь нь амждаггүй гэж хариулсан байна. Ихэвчлэн ээжүүдийн 49.6 хувь, аавуудын 15.9 хувь нь хүүхдэдээ үлгэр ном уншиж ярьж өгдөг байна.

Хүснэгт 12. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдээ үлгэр уншиж өгдөг эсэх

	Төвийн бүс	Хойд бүс	Баруун бүс	Урд бүс	Зүүн бүс	Нийт
Үлгэр, ном уншиж, ярьж өгдөггүй	12.0	11.1	8.3	8.3	5.6	9.9
Үлгэр, ном уншиж, ярьж өгдөг	88.0	88.9	91.7	91.7	94.4	90.1

Хүүхдийн амьдарч буй бүсээр авч үзэхэд бүх бүсийн эцэг эх, асран хамгаалагчид хүүхэдтэйгээ хамтран уншиж, ярьж өгч байгаа ч зүүн болон баруун, урд бүсэд амьдарч буй эцэг эх, асран хамгаалагч нь илүү өндөр хувьтай (94.4 - 91.7) уншиж өгдөг байна.


Хүснэгт 13. Үлгэр, ном уншиж өгдөг эсэх бүхээр

	Төвийн бүс	Хойд бүс	Баруун бүс	Урд бүс	Зүүн бүс	Нийт
--	------------	----------	------------	---------	----------	------

Үгүй	5.6	8.3	5.6	5.6	2.8	5.6
Ээж нь	51.9	47.2	44.4	41.7	58.3	49.6
Аав нь	15.7	13.9	11.1	25.0	13.9	15.9
Ах, эгч нь	13.0	13.9	19.4	16.7	8.3	13.9
Өвөө, эмээ нь	13.9	16.7	19.4	11.1	16.7	15.1

Бүсээр авч үзэхэд хүүхдийн хөгжлийг дэмжигч нь хүүхдийн ээж байна гэж харж болохоор байна. Хүснэгтээс хархад урд бүсэд амьдарч буй хүүхдийн аавуудын оролцоо бусад бүсэд амьдарч буй аавуудын оролцооноос өндөр байна.

Зураг 4. Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны оролцоо



Эцэг эх, асран хамгаалагчид СӨБ-ын сургалтыг дэмжих зорилгоор зохион байгуулж буй үйл ажиллагаанд хүүхдээ оролцуулахдаа ихэвчлэн урлагийн үзлэг 32.5 хувь, бүжиг, гимнастикийн дугуйлан тэмцээнд оролцуулдаг гэсэн бол бусад зохион байгуулж буй ажилд оролцуулдаг гэх 37.3 хувь нь хариулсан байгаагаас хүүхэд бүрийн оролцоог хангах ажил зохион байгуулдаг байна гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 14. Хүүхдийн оролцоо эцэг эх асран хамгаалагчдын харцултаар бүсээр

	Төвийн бүс	Хойд бүс	Баруун бүс	Урд бүс	Зүүн бүс	Нийт
Гимнастик	13.9	11.1	19.4	33.3	0.0	15.1
Урлагийн үзлэг	27.8	38.9	25.0	38.9	41.7	32.5
Бүжиг	18.5	13.9	16.7	8.3	11.1	15.1
Бусад	39.8	36.1	38.9	19.4	47.2	37.3

Зүүн болон урд бүсийн хувьд ихэвчлэн урлагийн үзлэгт оролцдог бол төвийн болон зүүн, баруун бүсийн хүүхдийн оролцоо олон төрлийн үйл ажилд чигэлдэг байна гэж үзэж болохоор байна.

Судалгаанд хамрагдсан эцэг эх, асран хамгаалагчдаас хүүхдийн хөгжилтэй холбоотой чадвар болох хэл яриа, хөдөлгөөн, сэтгэл хөдлөлөө хэрхэн илэрхийлж буйг 5 түвшингээр үнэлүүлсэн.

Хүснэгт 15. Хүүхдийн чадваруудыг эцэг эх, асран хамгаалагчид үнэлсэн байдал

Чадварууд	Сул	Дундаж	Сайн	Маш сайн
Өөрийн санаа бодлоо яриагаар илэрхийлдэг	0.8	9.1	29.4	60.7
Баярлаж, уурлаж байгаа гэх мэт сэтгэлийн хөдөлгөөнийг таньдаг	0.8	2.8	29.4	67.1
Өгсөн зааврын дагуу бие даан тухайн үйлдлийг хийдэг	1.6	4.8	38.9	54.8
Сонирхоод хийж байгаа зүйлээ дуустал нь хийдэг	1.2	13.5	38.5	46.8
Гараа угаах, шүдээ угаах гэх мэт дадалтай	0.4	9.5	34.1	56.0
Өөрөө халбага, сэрээ, харандааг барьдаг	0.8	1.2	21.8	76.2
Үеийнхэнтэйгээ хамтарч тоглох дуртай	0.4	1.2	20.6	77.8

Саадыг давж гүйх, харайх үйлдэл хийдэг	1.2	7.1	31.3	60.3
Цамцны товчоо өөрөө товчилдог	2.0	7.5	34.1	56.3

Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ чадваруудыг сайн маш сайн түвшинд 60.0 - аас дээш хувьтай 5 чадварыг тэмдэглэсэн бол өгсөн зааврын дагуу 54.8 хувь нь бие даан маш сайн түвшинд үйлдэх хийдэг, сонирхоод хийж байгаа зүйлээ дуустал нь 46.8 хувь нь гүйцэтгэдэг, жижиг булчингийн оролцоо ихтэй цамцны товчыг 56.3 хувь өөрөө товчилдог гэж хариулсан байна.

Хүснэгт 16. Хүүхдийн хөдөлгөөн, тэнцвэр, дүрэм баримтлах, аюул тохиолдсон үед бусдаас тусламж авах чадваруудыг эцэг эх, асран хамгаалагчид үнэлсэн байдал.

	Бай онож тоглодог	Дуртай зүйлээ авах гэж уйлдаг	Аль нэг хөл дээрээ удаан тогтож тоглодог	Хөл ээлжлэн зогсож саванд хийдэг	Хогоо хогийн саванд хийдэг	Аюул тулгарсан үед бусдаас тусламж авдаг
Үгүй	26.2	31.0	10.3	0.8	Тусламж чаддаггүй	2.8
Хааяа	47.2	35.7	36.9	14.3	Зөвхөн эцэг, эх ах, эгчээсээ тусламж гуйдаг.	48.0
Тийм	26.6	33.3	52.8	84.9	Ойр орчимд байгаа хүмүүсээс тусламж гуйдаг.	49.2

Судалгаанд хамрагдсан хүүхдийн 47.2 хувь нь гэртээ хааяа бай онож тоголдог, 52.8 хувь нь аль нэг хөл дээрээ ээлжлэн удаан зогсож тоголдог гэж хөдөлгөөний талаарх үнэлгээ өгсөн бол олон нийтийн газар дүрэм журам баримтлах талаар дэлгүүрт ороод дуртай зүйлээ авах гэж 35.7 хувь нь хааяа уйлдаг, 84.9 нь ямар нэг цаас, хогоо заавал хогийн саванд хийдэг гэж эцэг эх, асран хамгаалагчид хариулсан байна.

Хүснэгт 17. Хүүхдийн хэл яриа, сэтгэлийн хөдөлгөөн нийгэмшлийн чадваруудын талаарх эцэг эх, асран хамгаалагчид үнэлсэн байдал

Чадвар	Өөрийн санаа бодлоо яриагаар илэрхийлдэг		Сэтгэлийн хөдөлгөөнийг таньж ойлгодог		Өгсөн зааврын дагуу бие даан үйлдэл хийдэг		Сонирхоод хийж байгаа зүйлээ дуустал нь хийдэг	
	Судалгаа 1	Судалгаа 2	Судалгаа 1	Судалгаа 2	Судалгаа а 1	Судалгаа а 2	Судалгаа а 1	Судалгаа а 2
Түвшин	1	2	1	2	а 1	а 2	а 1	а 2
Сул	2.1	0.8	0.0	0.8	0.0	1.6	4.2	1.2
Дундаж	9.7	9.1	2.1	2.8	11.1	4.8	11.8	13.5
Сайн	41.7	29.4	41.7	29.4	45.8	38.9	45.1	38.5
Маш сайн	46.5	60.7	56.3	67.1	43.1	54.8	38.9	46.8

Өмнөх судалгаатай харьцуулан авч үзэхэд эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн хөгжлийг өөрийн санаа бодлоо яриагаар маш сайн илэрхийлдэг, сэтгэлийн хөдөлгөөнийг таньж ойлгодог, өгсөн зааврын дагуу бие даан маш сайн гүйцэтгэх чадвартай, ямар нэг зүйл сонирхоод хийж эхэлсэн бол дуустал нь хийдэг гэсэн хариултууд нэмэгдсэн байна.

Хүснэгт 18. Хүүхдийн хөгжлийн талаарх эцэг эх, асран хамгаалагчид үнэлсэн байдал

Чадвар	Гараа угаах, шүдээ угаах гэх мэт дадал		Өөрөө халбага, сэрээ, харандаа барьдаг		Үеийнхэнтэйгээ хамтарч тоглох		Саадыг давж гүйх, харайх зэрэг үйлдэл	
Түвшин	Судалгаа 1	Судалгаа 2	Судалгаа 1	Судалгаа 2	Судалгаа 1	Судалгаа 2	Судалгаа 1	Судалгаа 2
Сул	1.4	0.4	0.0	0.8	0.0	0.4	1.4	1.2
Дундаж	6.9	9.5	4.2	1.2	2.1	1.2	11.1	7.1
Сайн	45.1	34.1	22.2	21.8	26.4	20.6	39.6	31.3
Маш сайн	46.5	56.0	73.6	76.2	71.5	77.8	47.9	60.3

Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн гар, шүдээ угаах дадал, өөрөө халбага сэрээ, харандаагаа барих, үеийнхэнтэйгээ хамтрах тоглох, саад давж гүйж харайх үйлдлүүдийг хийх нь өмнөх судалгааны үр дүнгээс 12.4 - 2.6 хувиар өссөн байна.

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан хүүхдүүд нас, хүйсийн хувьд тэнцвэртэй байна.
- Хүүхдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй жил нэмэгдсэн байна.
- Судалгаанд хамрагдсан хүүхдийн 63.0 хувь нь 4-5 гишүүнтэй өрхөд амьдардаг, хүүхдийн 88.9 хувь нь гэртээ, 11.1 хувь нь эмээ өвөөгийн дөө амьдарч байна.
- Хүүхдүүдийн 48.8 хувь нь цэцэрлэгээсээ 500-1 км зайтай газар амьдардаг, төвийн бүсийн хүүхдийн 8.3 хувь нь 4 өөс дээш км-т байрлах цэцэрлэгт хамрагддаг байна.
- Хойд бүсэд амьдарч буй аавуудын 32.4 хувь нь төсвийн байгууллагад, баруун бүсэд амьдарч буй аавуудын 36.1 хувь нь төсвийн байгууллагад ажиллаж байгаа бол урд болон зүүн бүсэд амьдарч буй аавуудын 33.3-30.6 хувь нь малчин байна.
- Зүүн болон хойд бүсэд амьдарч буй ээжүүдийн 25.0 - 27.8 хувь нь малчин бол баруун бүсэд амьдарч буй ээжүүдийн 13.9 хувь нь ажил эрхэлдэггүй байна.
- Хоёр дахь шатны судалгаанд хамрагдсан эцгийн 2.4 хувь, эхийн 7.5 хувь ажил эрхлээгүй, эцгийн 21.8 хувь малчин, эхийн 48.4 хувь нь төсвийн байгууллагад ажилладаг байна.
- Судалгаанд хамрагдсан хүүхдийн эцгийн боловсролын түвшинг судалгаа 1 ба 2 той харьцуулан авч үзэхэд дээд боловсрол эзэмшилт 2.2 хувь нэмэгдсэн, тусгай дунд боловсрол, суурь боловсрол эзэмшилт 1-1.1 хувь буурсан, боловсрол эзэмшээгүй 1.7 хувь буурсан байна.
- Төсвийн байгууллагад эцгийн ажиллаж буй байдал 6.0 хувь нэмэгдсэн бол хувиараа жижиг бизнес эрхлэлт 1.8 хувь, малчин 2.5 хувь, ажилгүйдэл 5.2 хувь буурсан байна. Эхийн төсвийн байгууллагад ажиллах нь 4.6 хувь нэмэгдсэн бол хувиараа жижиг бизнес эрхэлж буй байдал 4.1 хувь буурсан, ажилгүй гэсэн хариулт 3.6 хувиар буурсан нь ажил эрхлэлт бага зэрэг нэмэгдсэн байна гэж харж болохоор байна.
- Хүүхдийн амьдарч буй өрхийн сарын орлого 5 жилийн өмнөх судалгааны үзүүлэлттэй харьцуулахад нэмэгдсэн байна.
- Хүүхдийн амьдарч буй өрхийн сарын орлогыг бүсээр авч үзэхэд 5 бүсийн өрхүүдийн 64.0-71.3 хувь нь 1 сая 101 мянгаас 1 сая 501 мянган төгрөгний орлоготой гэр бүлд амьдарч байна. Төвийн бүсийн хүүхдийн 71.3 хувь нь хамгийн өндөр орлоготой гэр бүлд амьдарч байна.
- Судалгаанд хамрагдсан хүүхдийн 90.1 хувь нь уншиж өгдөг, ихэвчлэн ээжүүдийн 49.6 хувь, аавуудын 15.9 хувь нь хүүхдэдээ үлгэр ном уншиж ярьж өгдөг байна.
- Хүүхдийн амьдарч буй бүсээр авч үзэхэд бүх бүсийн эцэг эх, асран хамгаалагчид хүүхэдтэйгээ хамтран уншиж, ярьж өгч байгаа ч зүүн болон баруун, урд бүсэд амьдарч буй эцэг эх, асран хамгаалагч нь илүү өндөр хувьтай (94.4 - 91.7) уншиж өгдөг байна.
- Эцэг эх, асран хамгаалагчид СӨБ-ын сургалтыг дэмжих зорилгоор зохион байгуулж буй үйл ажиллагаанд хүүхдээ оролцуулахдаа ихэвчлэн урлагийн үзлэг 32.5 хувь, бүжиг, гимнастикийн дугуйлан тэмцээнд оролцуулдаг гэсэн бол бусад зохион байгуулж буй

ажилд оролцуулдаг гэх 37.3 хувь нь хариулсан байгаагаас хүүхэд бүрийн оролцоог хангах ажил зохион байгуулдаг байна гэж үзэж болохоор байна.

- Эцэг эх, асран хамгаалагчид хүүхэд нь өгсөн зааврын дагуу 54.8 хувь нь бие даан маш сайн түвшинд үйлдэх хийдэг, сонирхоод хийж байгаа зүйлээ дуустал нь 46.8 хувь нь гүйцэтгэдэг, жижиг булчингийн оролцоо ихтэй цамцны товчыг 56.3 хувь өөрөө товчилдог гэж үнэлсэн байна.
- Судалгаанд хамрагдсан хүүхдийн 47.2 хувь нь гэртээ хааяа бай онож тоголдог, 52.8 хувь нь аль нэг хөл дээрээ ээлжлэн удаан зогсож тоголдог гэж хөдөлгөөний талаарх үнэлгээ өгсөн бол олон нийтийн газар дүрэм журам баримтлах талаар дэлгүүрт ороод дуртай зүйлээ авах гэж 35.7 хувь нь хааяа уйлдаг, 84.9 нь ямар нэг цаас, хогоо заавал хогийн саванд хийдэг гэж хариулсан байна.
- Өмнөх судалгаатай харьцуулан авч үзэхэд эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн хөгжлийг өөрийн санаа бодлоо яриагаар маш сайн илэрхийлдэг, сэтгэлийн хөдөлгөөнийг таньж ойлгодог, өгсөн зааврын дагуу бие даан маш сайн гүйцэтгэх чадвартай, ямар нэг зүйл сонирхоод хийж эхэлсэн бол дуустал хийдэг талаарх хариултын хувь нэмэгдсэн байна.
- Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн гар, шүдээ угаах дадал, өөрөө халбага сэрээ, харандаагаа барих, үеийнхэтэйгээ хамтрач тоглох, саад давж гүйж харайх үйлдлүүдийг хийх нь өмнөх судалгааны үр дүнгээс 12.4 - 2.6 хувиар өссөн байна.

1.1 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ

Хүүхдийн бие бялдын хөгжлийн үзүүлэлтүүдийг авч үзэхдээ өсөлт, хөгжил гэсэн ойлголтыг авч үздэг. Хүүхдийн бие бялдын хөгжил нь хүүхдэд бие бялдар, танин мэдэхүй, нийгэм сэтгэл зүйн хувьд өөрчлөлт ахиц гарч шинэ түвшинд хүрэх тухай ойлголт юм.

0-1 нас эрчимтэй өсөлтийн анхны үе
 1 -3 нас бие бялдын эрчимтэй өсөлт буурах үе
 4 - 7 нас жилд дунджаар 7-10 см өсч биеийн жин нэмэгдэх эрчимтэй өсөлтийн хоёр дахь үе

1.1.1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН ӨСӨЛТ/ЕРӨНХИЙ ХӨГЖИЛ

Хүүхдийн бие бялдын өсөлтийн үзүүлэлтийг толгойн тойрог, биеийн жин, биеийн өндөр, цээжний тойрог, бүсэлхийн тойрог гэсэн үзүүлэлтүүдээр авч үзсэн. Сорил тус бүр нь нарийвчлалтайгаар хэмжигдсэн бөгөөд тухайн насны онцлогт тохирсон байдлаар хэмжилтүүд хийгдсэн.

Хүснэгт 19. Бие бялдын өсөлтийн статистик үзүүлэлт


Үзүүлэлт	нас	Хүйс	Дундаж	Ст. Хаз	Ст. Алдаа	Итгэх мужДундаж		Бага утга	Их утга	t утга		
						Доод	Дээд					
Толгойн тойрог (см)	3	хөвгүүд	50.90	1.91	0.29	50.30	51.49	47.00	54.20	4.345**		
		охид	49.35	1.79	0.28	48.79	49.91	46.00	53.50			
	4	хөвгүүд	51.45	1.71	0.26	50.91	51.98	45.50	56.00			
		охид	50.69	1.56	0.24	50.20	51.17	47.00	55.10			
	5	хөвгүүд	52.04	1.73	0.27	51.50	52.58	49.00	58.00			
		охид	51.39	1.29	0.20	50.98	51.79	49.00	55.00			
	Биеийн жин (кг)	3	хөвгүүд	16.45	2.21	0.34	15.76	17.14	12.10		21.70	2.278
			охид	15.33	1.81	0.28	14.76	15.89	11.50		21.20	
4		хөвгүүд	18.65	1.97	0.30	18.04	19.26	16.00	24.30			
		охид	18.21	2.87	0.44	17.31	19.10	12.50	31.00			
5		хөвгүүд	21.36	3.61	0.56	20.24	22.49	16.30	33.80			
		охид	20.20	1.79	0.28	19.64	20.75	16.50	25.00			
Биеийн өндөр (см)		3	хөвгүүд	100.74	6.18	0.95	98.81	102.66	89.5	114.8	1.649	
			охид	97.41	4.82	0.74	95.91	98.91	89.5	112.4		
	4	хөвгүүд	107.72	5.14	0.79	106.12	109.32	98.0	119.5			
		охид	107.03	5.67	0.87	105.27	108.80	93.1	117.5			
	5	хөвгүүд	113.39	5.11	0.79	111.80	114.98	93.0	124.0			
		охид	112.57	4.27	0.66	111.24	113.90	102.3	120.3			
		3	хөвгүүд	53.89	2.82	0.44	53.01	54.77	46.5	60.0		3.226**
			охид	52.00	2.03	0.31	51.36	52.63	47.0	56.0		
4		хөвгүүд	55.55	2.39	0.37	54.80	56.29	50.0	60.0			
		охид	54.57	2.98	0.47	53.63	55.52	50.0	67.5			

Цээжний тойрог (см)	5	хөвгүүд	58.61	4.71	0.73	57.14	60.07	51.0	78.0
		охид	56.98	3.02	0.47	56.04	57.92	51.0	65.0
Бүсэлхийн тойрог (см)	3	хөвгүүд	52.76	3.55	0.55	51.66	53.87	45.0	59.0
		охид	50.95	2.76	0.43	50.09	51.81	45.0	58.0
	4	хөвгүүд	53.67	3.53	0.54	52.57	54.77	43.0	63.0
		охид	53.54	3.87	0.60	52.33	54.74	44.0	61.0
	5	хөвгүүд	56.00	5.61	0.87	54.25	57.75	48.2	80.0
		охид	53.59	2.86	0.44	52.70	54.48	49.0	60.0

2.884**


Дээрх хүснэгтээс хархад 3 настай хүүхдийн үзүүлэлт өмнөх судалгааны дундаж үзүүлэлтээс толгойн тойрог 0.5 см, биеийн өндөр 0.9 см-ээр нэмэгдсэн бол, биеийн жин 0.6 гр, цээжний тойрог 1 см-аар буурсан, бүсэлхийн тойрог дундаж үзүүлэлтээс өөрчлөгдөөгүй байна.

Зураг 5. Толгойн тойрог насаар




Хүүхдүүдийн нас нэмэгдэх тусам тойлгойн тойргийн хэмжээ нэмэгдсэн нь физиологийн хөгжлийн дагуу ядагдаж байна.

Зураг 6. Толгойн тойрог охид бүсээр




Зураг 7. Толгойн тойрог хөвгүүд



Биеийн жин


Хүүхдийн биеийн жин нь өсөлтийг илэрхийлэх гол үзүүлэлт бөгөөд нас нэмэгдэх тусам 1-3 кг аар нэмэгдэж байдаг байна.

Зураг 8. Биеийн жин насаар



Судалгаанд хамрагдсан хүүхдийн биеийн жин нь нас нэмэгдэх тусам охидын хувьд 2.9 кг -2.0 кг аар нэмэгдсэн, хөвгүүдийн биеийн жин 2.3 кг – 2.7 кг аар тус тус нэмэгдсэн нь өсөлт физиологийн хөгжлийн дагуу ядагдаж буйг илэрхийлж байна.

Зураг 9. Охидын биеийн жин бүсээр




Судалгаанд хамрагдсан охидын хувьд нас нэмэгдэх тусам 3.1- 1.9 кг -аар нэмэгдсэн байна. Бүсээр авч үзэхэд охидын биеийн жин нас тус бүрд жигд үзүүлэлттэй байна.

Зураг 10. Хөвгүүдийн биеийн жин бүсээр



Хөвгүүдийн биеийн жин нас нэмэгдэх тусам 2.1-3.3 кг аар нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа ба бүсийн хувьд ч жигд байна.

Зураг 11. Судалгаа 1 ба 2 биеийн жингийн харьцуулсан үзүүлэлт




Судалгаа 1 ба 2 оор харьцуулан авч үзэхэд 4 ба 5 настай хөвгүүдийн биеийн жин 1 кг-аас 1.2 кг -аар нэмэгдсэн, охидын биеийн жин 0.7-0.9 гр -аар нэмэгдсэн байна.

Биеийн өндөр

Хүүхдийн биеийн өндрийн үзүүлэлт нь хүүхдийн өсөлтийг илэрхийлдэг гол чадвар бөгөөд хүүхдийн онцог, нас хүйс, эрүүл мэндийн байдлыг илэрхийлдэг.

Зураг 12. Биеийн өндөр насаар



Судалгаанд хамрагдсан охидын биеийн өндрийн үзүүлэлт нас нэмгэдэх тусам 9.6 см-5.6 см -ээр, хөвгүүдийн биеийн өндөр 7.0 см -5.7 см байгаа нь физиологийн хөгжлийн дагуу явагдаж буйг илэрхийлж байна.

Зураг 13. Охидын биеийн өндрийн үзүүлэлт бүсээр




Охидын биеийн өндрийн үзүүлэлтийг бүсээр авч үзэхэд зүүн бүсийн охид аль ч насанд өндөр, төвийн бүсэд амьдарч буй 5 настай охид бусад бүсийн охидоос 4.4 см- 1.2 см -ээр намхан байна.

Зураг 14. Хөвгүүдийн биеийн өндрийн үзүүлэлт бүсээр



Хөвгүүд охидын биеийн өндрийн үзүүлэлт нас нэмэгдэх тусам өссөн ба төвийн бүсийн 5 настай хөвгүүдийн дундаж өндөр 115.1 см байгаа бол зүүн бүсэд амьдарч буй 5 настай хөвгүүд 4.5 см -ээр намхан байгаа бол 5 настай охидын хувьд төвийн бүсийн охид зүүн бүсийн охидоос 4.6 см -ээр намхан байна.

Зураг 15. Судалгаа 1 ба 2 биеийн өндрийн харьцуулсан үзүүлэлт




Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулан үзэхэд хөвгүүдийн хувьд 3 насанд 0.6 см намхан, 4 насанд 1.4 см -ээр өндөр, охидын хувьд 3 насанд 2.1 см -ээр 5 насанд 0.6 см-ээр тус тус буурсан байна.

Цээж, бүсэлхийн тойрог


Цээж, бүсэлхийн тойрог нь хүүхдийн өсөлтийг, эрүүл мэндийг илэрхийлэх чухал үзүүлэлт юм.

Зураг 16. Бүсэлхийн тойрог насаар




Судалгаанд хамрагдсан охидын бүсэлхийн тойргийн хэмжээ 3-4 насанд нэмэгдсэн харин 4-5 насанд өөрчлөгдөөгүй байна. Хөвгүүдийн хувьд нас нэмэгдэх тусам 0.9см – 2.3 см ээр нэмэгдсэн байгаа нь зүй тогтолын дагуу өсөж байгааг илэрхийлж байна.

Зураг 17. Цээжний тойрог насаар




Судалгаанд хамрагдсан хүүхдийн цээжний тойрог нас нэмэгдэх тусам охидын 2.6см- 2.4 см ээр нас нэмэгдэх тусам нэмэгдсэн, хөвгүүдийн хувьд 1.6 см-3.1 см нэмэгдсэн байгаа нь физиологийн хөгжлийн дагуу явагдаж байна.

Зураг 18. Хөвгүүдийн цээжний тойрог бүсээр



Охид, хөвгүүдийн цээжний тойргийн үзүүлэлт нас нэмэгдэх тусам 1.3- 3.9 см-ээр, охидын хувьд 1 см - 5.8 см- ээр тус тус нэмэгдсэн байна. Бүсийн хувьд нас тус бүрээр нэмэгдсэн ба жигд өсөлттэй байна.

Зураг 19. Судалгаа 1 ба 2 цээжний тойрог



Судалгаа 1 ба 2 оор харьцуулан үзэхэд хөвгүүд 3 насанд цээжний тойрог 2.1 см буурсан, 5 насанд 0.9 гр -аар нэмэгдсэн охидын хувьд 3-4 насанд өмнөх судалгааны үр дүнгээс буурсан 5 насанд өөрчлөгдөөгүй байна.

Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулан үзэхэд 3 насны хөвгүүдийн цээжний тойрог 2.1 см, 4 насанд 0.6 см, охидын хувьд 3 насанд 2.1 см, 4 насанд 0.9 см -ээр бага байгаа нь цээжний тойрог буурсан нь биеийн хэлбэр өөрчлөгдөж байгааг харуулж байна.

Зураг 20. Охидын бүсэлхийн тойрог бүсээр




Бүсэлхийн тойрог нь биеийн зөв хэлбэрийг илэрхийлдэг бөгөөд урд бүсэд амьдарч буй 5 настай охидын биеийн жин бүх бүсэд ойролцоо 20.8 кг байгаа ч бүсэлхийн тойрог 58.5 см байгаа нь өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 21. Охидын бүсэлхийн тойрог бүсээр




Охидын хувьд зүүн бүсэд амьдарч буй охидын бүсэлхийн тойрог нас нэмэгдэх тусам өссөн үзүүлэлттэй ч бусад бүсийн охидоос бага, хойд бүсэд амьдарч буй 4 насны охид бусад бүх насны охидоос том буюу 5 насны охидоос 1.8 кг -аар илүү байгаа нь биеийн хэлбэр алдагдсан байгааг харуулж байна.

Зураг 22. Хөвгүүдийн бүсэлхийн тойрог бүсээр



Охидын бүсэлхийн тойрог нас нэмэгдэх тусам өссөн байгаа ч хойд бүсийн 4 настай охидын бүсэлхийн тойрог 57.2 см байгаа нь цээний тойрогтойгоо адил хэмжээтэй байгаа нь биеийн хэлбэрт өөрчлөлт орж байгааг харуулж байна.

Зураг 23. Судалгаа 1 ба 2 бүсэлхийн тойрог



Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулан үзэхэд 3 насны хөвгүүдийн бүсэлхийн тойрог 0.5 см буурсан, 4 насанд 0.9 см нэмэгдсэн, 5 насанд 1.9 см нэмэгдсэн нь анхаарал татаж байна. Охидын хувьд 3 насанд 0.9 см буурсан, 4 насанд 0.8 см -ээр нэмэгдсэн байгаа нь биеийн хэлбэр алдагдаж байгааг илэрхийлж байна.

Хүүхдүүдийн үзүүлэлтийг бүсээр авч үзэхэд:

- Зүүн бүсийн хүүхдийн бүх үзүүлэлт хамгийн бага байна (толгойн тойрог, биеийн өндөр, биеийн жин, цээжний тойрог, бүсэлхийн тойрог).
- Төвийн бүсийн хүүхдийн үзүүлэлтүүд хамгийн өндөр буюу дундажаас дээш байна.

Толгойн тойрог

- Нийт дундаж: 50.9 см
- Зүүн бүс: 48.0 см — хамгийн бага
- Хойд/Баруун бүс: 51.7 см — хамгийн өндөр

Биеийн жин

- Нийт дундаж: 16.4 кг
- Урд бүс: 15.9 кг — хамгийн бага
- Төв бүс: 16.7 кг — хамгийн их
- Хойд бүсийн стандарт хазайлт өндөр (3.4)

Биеийн өндөр

- Нийт дундаж: 100.7 см
- Төв бүс: 102.8 см — хамгийн өндөр
- Хойд бүс: 99.6 см — стандарт хазайлт өндөр (9.1) → хүүхдийн өсөлт ялгаатай

- Зүүн бүс: 98.9 см — хамгийн бага, стандарт хазайлт бага

Цээжний тойрог

- Нийт дундаж: 53.9 см
- Зүүн бүс: 50.0 см — хамгийн бага
- Төв бүс: 54.9 см — хамгийн их

Бүсэлхийн тойрог

- Нийт дундаж: 52.8 см
- Зүүн бүс: 47.9 см — хамгийн бага
- Баруун бүс: 53.8 см — хамгийн их гэх мэт үзүүлэлттэй байна.

1.1.2 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН БИЕ БЯЛДРЫН БЭЛТГЭЛЖИЛТ

Хүүхдийн бие бялдрын бэлтгэлжилтийг хурд, авхаалж самбаа, уян хатан, тэсвэр, хүчний үзүүлэлтийг хөлийн хүч, гарын хүчний үзүүлэлтэр авч үзсэн. 3–5 насны хүүхдийн бие бялдрын бэлтгэлжилт нь тэдний хөгжлийн суурь үндэс бөгөөд хурд, уян хатан байдал, авхаалж самбаа, тэнцвэр, хөлийн хүч, тэсвэр зэрэг чадваруудын гүйцэтгэлээр хэмжигддэг. Энэхүү судалгаанд охид, хөвгүүдийн гүйцэтгэлийг нас, судалгааны аргачлалаар харьцуулан дүн шинжилгээ хийж, хөгжлийн хандлага, хүйсийн ялгаа, орчны нөлөөллийг тодорхойлов.

Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөртэй уялдуулах нь авч үзэхэд Монгол Улсын Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилгийг “ ... хүүхдийн бие бялдрын хөгжлийг дэмжиж, танин мэдэхүй, нийгэмшлийн суурь болон ерөнхий чадамжийг эзэмшүүлж, сургуульд бэлтгэхэд оршио” гэж (2025)¹ тодорхойлсон байна. Тус хөтөлбөрт чадамжийн хүрээг “Биеий болон сэтгэл зүйн эрүүлмэнд, сайн сайхан байдал” – суурь чадамжийг Хөдөлгөөний эв дүй, хурд хүч, уян хатан, тэсвэр, тэнцвэрийг сайжруулах дасгал, хөдөлгөөнт тоглоомд идэвхтэй оролцох гэж тусгасан байна.

СӨБ -ын “Хөдөлгөөн, эрүүл мэнд” - хөтөлбөрийн хүрэх үр дүнг “ – хүүхэд алхах, гүйх, үсрэх зэрэг хөдөлгөөнийг гүйцэтгэж, тэнцвэрээ хадгалах, зүг чигээ баримжаалах чадвартай болж, эв дүй авхаалж самбаа, хариу үйлдэл шаардсан хөдөлгөөнт тоглоомд дүрмийн дагуу идэвхтэй оролцон, дасгал хөдөлгөөнийг зааврын дагуу зөв хийдэг болно гэж тодорхойлсон нь судалгааны сорилын арга түүнийг тодруулхад чиглэсэн байна.

Хүснэгт 20. Бие бялдрын бэлтгэлжилтийн чадваруудын статистик үзүүлэлт (4 нас хөвгүүд)

Чадвар	Нас	Хүйс	Дундаж	Ст.хаза	Ст.хаза	Итгэх муж		Хамгий н бага	Хамгий н их	t утга
				йлт	йлт	Доод	Дээд			
Хурд (сек)	3	хөвгүүд	3.96	0.73	0.11	3.73	4.19	2.58	6.10	- 2.934 **
		охид	4.28	0.69	0.11	4.06	4.49	3.00	5.60	
	4	хөвгүүд	3.47	0.70	0.11	3.25	3.69	2.00	5.21	
		охид	4.02	1.29	0.20	3.62	4.42	2.10	10.10	
	5	хөвгүүд	3.17	0.64	0.10	2.97	3.37	1.57	4.30	
		охид	3.28	0.54	0.08	3.12	3.45	1.58	4.15	
Уян хатан (см)	3	хөвгүүд	5.83	3.28	0.51	4.80	6.85	-2.10	13.20	- 3.553 **
		охид	7.61	2.85	0.44	6.72	8.50	2.00	13.60	
	4	хөвгүүд	6.65	3.61	0.56	5.53	7.77	-3.00	16.00	
		охид	8.24	3.21	0.49	7.25	9.24	1.50	16.00	
	5	хөвгүүд	5.47	3.42	0.53	4.40	6.53	-8.00	12.00	
		охид	6.74	4.13	0.64	5.45	8.02	-1.00	16.00	

¹ Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр Улаанбаатар 2025

Авхаал ж самбаа (удаа)	3	хөвгүүд	1.36	0.88	0.14	1.08	1.63	0.0	3.0	0.601
		охид	1.29	0.97	0.15	0.98	1.59	0.0	4.0	
	4	хөвгүүд	0.90	0.79	0.12	0.66	1.15	0.0	3.0	
		охид	0.81	0.67	0.10	0.60	1.02	0.0	2.0	
	5	хөвгүүд	0.93	0.78	0.12	0.69	1.17	0.0	3.0	
		охид	0.90	0.79	0.12	0.66	1.15	0.0	3.0	
Тэнцвэр (см)	3	хөвгүүд	9.54	10.19	1.57	6.37	12.72	0.88	47.37	-
		охид	8.53	10.03	1.55	5.40	11.66	1.00	66.32	
	4	хөвгүүд	16.89	15.64	2.41	12.02	21.77	1.80	94.00	
		охид	19.31	12.74	1.97	15.34	23.28	1.08	67.31	
	5	хөвгүүд	27.89	34.17	5.27	17.24	38.54	1.62	180.11	
		охид	27.14	16.68	2.57	21.94	32.33	1.88	81.00	
Хөлийн хүч (см)	3	хөвгүүд	67.40	18.75	2.89	61.55	73.24	30.00	112.10	3.241
		охид	53.03	14.79	2.28	48.42	57.64	30.00	88.00	
	4	хөвгүүд	86.41	22.05	3.40	79.54	93.28	49.50	142.00	
		охид	75.53	15.82	2.44	70.61	80.46	39.00	106.00	
	5	хөвгүүд	100.81	19.84	3.06	94.63	106.99	49.00	137.00	
		охид	96.50	17.47	2.70	91.06	101.94	61.00	138.40	
Тэсвэр (сек)	4	хөвгүүд	69.32	16.87	2.63	64.00	74.65	5.11	111.01	-
		охид	72.46	20.62	3.18	66.03	78.89	2.05	120.52	
	5	хөвгүүд	65.56	21.64	3.38	58.73	72.39	34.78	150.59	
		охид	70.16	19.86	3.06	63.97	76.35	46.14	137.76	


Тэсвэрийн чадварын (дундаж хугацаа 96.93) болон хөлийн хүч (77.50 сек) нь хамгийн өндөр дундаж үзүүлэлттэй байна. Тэнцвэр болон уян хатан байдал нь хэлбэлзэл ихтэй, зарим хүүхэд маш сайн, зарим нь сул үзүүлэлттэй гэж үзэж болно. Энэ нь бүс нутгийн, орчны, эсвэл дасгал сургуулилын ялгаатай байдалтай холбоотой байж болно. Хурд нь тогтвортой, бага хэлбэлзэлтэй чадвар бөгөөд ихэнх хүүхдүүд ойролцоо түвшинд байна.

Хөвсгөл аймгийн бүсүүдийн хооронд бие бялдрын чадварын ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, **тэнцвэр**, **тэсвэр**, **хөлийн хүч** зэрэг чадварууд нь зарим бүсэд илт давуу байгаа шалтгааныг тодруулан үзэх шаардлагатай байна. Харин **авхаалж самбаа** нь бүх бүсэд харьцангуй сул байгаад анхаарах.

Хурдны чадвар

Хурдны чадвар нь хүүхдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт бөгөөд гүйцэтгэлийг хугацаагаар хэмжигддэг. Энэхүү хэсэгт Хөвсгөл аймгийн таван бүсийн 3-5 настай охидын 50 метрийн гүйлтийн дундаж хугацааг харьцуулан дүн шинжилгээ хийв.

Зураг 24. Хурдны чадварын үзүүлэлт(сек)



Судалгаанд хамрагдсан хүүхдүүд 10 м зайг хамгийн хурданаараа туулсан хугацааг хэмжсэн ба нас нэмэгдэх тусам туулах хугацаа сайжирсан буюу 0.5 сек- 0.2 сек -ээр хурд сайжирсан байна.

Зураг 25. Охидын хурдны чадварын үзүүлэлт бүсээр (сек)



Охидын хурдны чадварыг бүсээр авч үзэхэд хойд, төв, урд болон зүүн бүсэд амьдарч буй охидын хурд зүй тогтолын дагуу сайжирсан үзүүлэлттэй, баруун бүсэд амьдарч буй охидын хувьд 4 насанд хурд буурсан байгаач 5 насны охид маш бага хугацаанд зайг туулсан дүр төрхтэй байна.

Зураг 26. Хөвгүүдийн хурдны чадварын үзүүлэлт бүсээр(сек)




Хүүхдүүдийн хурдыг 10 м зайг ямар хугацаагаар туулж байгаагаар хэмжсэн ба тухайн зайг богино хугацаанд туулах тусам хүүхдийн гүйцэтгэл сайн байна. Хүүхдийн нас нэмэгдэх тусам хурдтайгаар туулах чадвар сайжирч байна. Баруун бүсийн 5 настай охидын хувьд 10 м зайг хамгийн хурдан буюу 2.6 секундэд туулсан бол төвийн болон хойд бүсийн охид 3.5 секундэд туулсан байна. Хөвгүүдийн хувьд жигд гүйцэтгэлтэй байгаа ба баруун бүсэд амьдарч буй хүүхдүүд хурдтай гүйцэтгэж байгаа бол хойд бүсийн хөвгүүд хурд жигд байна.

Хүснэгт 21. Хурдны чадварын бүсийн үзүүлэлт насаар

Бүс	3 нас	4 нас	5 нас	Үзүүлэлт
Төвийн бүс	4.2 сек	4.1 сек	3.5 сек	Хурд нэмэгдсэн
Хойд бүс	4.3 сек	3.8 сек	3.5 сек	Нас нэмэгдэх тусам хурд сайжирсан
Баруун бүс	4.4 сек	3.9 сек	2.6 сек	Нас нэмэгдэх тусам хурд сайжирсан
Урд бүс	4.6 сек	4.0 сек	3.4 сек	Тогтвортой үзүүлэлт
Зүүн бүс	4.6 сек	3.7 сек	3.1 сек	Нас нэмэгдэх тусам хурд сайжирсан

Бүсийн охидын 10 метрийн гүйлтийн дундаж хугацаа нь нас ахих тусам сайжирч байгааг харуулж байна. Баруун бүсийн 5 настай охид хамгийн богино хугацаанд (2.6 сек) гүйсэн нь хөдөлгөөний идэвх, дасгалын чанар өндөр байгааг илтгэж байна.

Зураг 27. Судалгаа 1 ба 2 харьцуулалт хурдны чадвар (сек)




Хүүхдүүдийн тодорхой зайг хурдтайгаар туулах чадвар 4 настай хөвгүүдийн хувьд 0.3 сек -ээр буурсан, 5 насанд 0.3 сек -ээр хурдтай зайг туулсан бол охидын хувьд нас тус бүрд 0.2-0.5 секундээр илүү хурдтайгаар зайг туулсан байна. Хөвгүүдийн хурдны чадварын гүйцэтгэл нь нас ахих тусам сайжрах хандлагатай боловч хоёр судалгааны хооронд ялгаатай үр дүн гарч байна. Тухайлбал, Судалгаа 1-д 4 наснаас 5 нас хүртэл хурдны гүйцэтгэсэн хугацаа адил байгаа бол Судалгаа 2-д 5 насанд илүү хурдан гүйцэтгэл (3.2 сек) ажиглагдаж байна.

Уян хатан чадвар

Уян хатан чадвар нь хүүхдийн хөдөлгөөний чадамж, булчингийн суналт, биеийн тэнцвэрт байдалд нөлөөлдөг чухал үзүүлэлт юм. Энэхүү хэсэгт хоёр өөр судалгааны үр дүнд тулгуурлан 3–5 настай охид, хөвгүүдийн уян хатан байдлын дундаж үзүүлэлтийг харьцуулан, 4–5 жилийн өөрчлөлт болон хүйсийн ялгааг дүн шинжилгээ хийв.

Зураг 28. Уян хатан чадварын үзүүлэлт(см)



Хүүхдийн уян хатан чадвар хөвгүүдийн хувьд 3-4 насанд нэмэгдсэн бол 0.9 см-ээр нэмэгдсэн бол 5 насанд 1.2 см -эр буурсан бол охидын хувьд мөн адил 3-4 насанд 0.6 см -ээр нэмэгдсэн 5 насанд 1.5 см -ээр буурсан байгаа нь 5 насанд хөшүүн болж байгааг илэрхийлж байна. Хоёр судалгааны үр дүнг харахад охидын уян хатан чадвар хөвгүүдээс өндөр байгаа нь насны онцлогтой холбоотой байж болох юм.

Зураг 29. Охидын уян хатан чадвар бүсээр(см)



Хойд болон урд бүсийн 4 настай охид уян (11.8-10.0), харин хойд, урд, зүүн бүсийн 5 настай охидын уян хатан чадварын үзүүлэлт хамгийн бага (2.2-3.8) байгаа нь анхаарал татаж байна.

Төвийн бүсийн хүүхдийн хувьд тогтвортой өсөлттэй буюу нас нэмэгдэх тусам физиологийн өсөлтөөр хөгжиж байна.

Зураг 30. Хөвгүүдийн уян хатан чадвар бүсээр(см)



Хойд, урд бүсийн 4 настай хөвгүүдийн уян хатан чадвар (11.3-6.8 см), баруун бүсийн хөвгүүд 3 насанд хөшүүн (2.5см), зүүн, урд бүсийн хөвгүүд 5 насанд хөшүүн (4.2-2.8 см) байна. Зүүн бүсийн хөвгүүдийн хувьд 3 настай хүүхдийн үзүүлэлтээс 4 ба 5 насанд буурсан байгаа нь анхаарал татаж байна. Төвийн бүс тогтвортой боловч бага зэрэг буурсан хандлагатай байна.

Зураг 31. Судалгаа 1 ба 2 уян хатан чадвар




Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулан үзэхэд хөвгүүдийн уян хатан чадвар нас тус бүрд 0.9 - 1.5 см -ээр сайжирсан. Охидын хувьд 4 насанд 0.5 см хөшүүн болсон, харин 3 ба 5 насанд 1.8 см-1.2 см-ээр уян болсон байна. Судалгаа 1-д охидын уян хатан байдал 3-4 насанд тогтвортой өсч, 5 насанд бага зэрэг буурсан, судалгаа 2-т 4 насанд хөвгүүдийн гүйцэтгэл гарсан ч 5 насанд охидын давуу байдал эргэн сэргэж байна.

Авхаалж самбаатай чадвар

Хүүхдүүдийн авхаалж самбаатай чадварыг насны онцлогоос хамааран байг онуулах хэмжээ өөрчлөгдөж байсан ба 4 удаа байг онож, эс онож байгаагаар тооцсон.

Зураг 32. Авхаалж самбаатай чадварын үзүүлэлт




Хүүхдийн авхаалж самбаатай чадвар байг хэдэн удаа онсоноор авсан ба охидын хувьд дунджаар 1 удаа онож байсан бол хөвгүүдийн хувьд баруун бүсийн хөвгүүд 3 ба 4 насанд 2 удаа, зүүн бүсийн 3 настай хөвгүүд дунджаар 2 удаа оносон байна.

Тэнцвэрийн чадвар

Тэнцвэрийн чадвар нь хүүхдийн биеийн зохицуулалт, булчингийн хяналт, орон зайд өөрийгөө мэдрэх чадамжтай шууд холбоотой. Энэхүү хэсэгт 3-5 настай охид, хөвгүүдийн тэнцвэрийн чадварыг хоёр судалгааны үр дүнд тулгуурлан харьцуулан дүн шинжилгээ хийв.

Зураг 33. Тэнцвэрийн чадвар үзүүлэлт (сек)



Хүүхдийн наснэмэгдэх тусам тэнцвэрээ олж зогсох чадвар нэмэгдсэн байна. Охид хөвгүүдийн гүйцэтгэл жигд байна.

Зураг 34. Охидын тэнцвэрийн чадвар бүсээр(сек)




Хойд, баруун, зүүн бүсийн охидын тэнцвэрээ олох чадвар нас нэмэгдэх тусам сайжирсан бол урд бүсийн хүүхдийн гүйцэтгэл 3 наснаас 4 насанд 6.5 секундээр, 4-5 насанд 26.6 секундээр нэмэгдсэн байна.

Зураг 35. Хөвгүүдийн тэнцвэрийн чадвар бүсээр (сек)



Төвийн болон хойд, зүүн бүсийн хөвгүүдийн тэнцвэрийн чадвар нас нэмэгдэх тусам нэмэгдсэн бол баруун бүсийн хүүхдийн гүйцэтгэл жигд байна.

Зураг 36. Судалгаа 1 ба 2 тэнцвэрийн чадвар (сек)



Хүүхдийн нэг хөл дээрээ тэнцвэрээ олж зогсох чадвар хөвгүүдийн хувьд 1сек -3.7 секундээр нэмэгдсэн, охидын хувьд 3 насанд өмнөх судалгааны дундаж үзүүлэлтээс 1 секундээр буурсан 5 насанд 0.8 секундээр буурсан байна.

Хүснэгт 22. Тэнцвэрийн чадварын харьцуулсан үзүүлэлт

Нас	Судалгаа	Хөвгүүд	Охид	Хүйсийн ялгаа	Хандлага
3 нас	Судалгаа 1	4.6	5.6	+1.0 (Охид)	Охид тэнцвэрт чадвар сайтай
4 нас	Судалгаа 1	16.9	19.3	+2.4 (Охид)	
5 нас	Судалгаа 1	11.6	15.3	+3.7 (Охид)	
3 нас	Судалгаа 2	9.5	8.5	-1.0 (Хөвгүүд)	Өмнөх судалгаанаас гүйцэтгэл сайжирсан.
4 нас	Судалгаа 2	6.8	8.0	+1.2 (Охид)	
5 нас	Судалгаа 2	27.9	27.1	-0.8 (Хөвгүүд)	

Хоёр судалгааны үр дүнд тэнцвэрийн чадвар Судалгаа 1-д охид бүх насанд хөвгүүдээс илүү гүйцэтгэлтэй, Судалгаа 2-т 3 болон 5 насанд хөвгүүд гүйцэтгэл сайтай байна.

Хүчний чадвар

Хөлийн хүчний чадвар нь хүүхдийн булчингийн чадамж, тэнцвэр, хөдөлгөөний зохицуулалттай шууд холбоотой бөгөөд байрнаас уртад харайх сорилын гүйцэтгэлээр хэмжигддэг. Энэхүү хэсэгт 3-5- насны охид, хөвгүүдийн гүйцэтгэлийг хоёр судалгааны үр дүнд тулгуурлан харьцуулан дүн шинжилгээ хийв. хүүхдийн хүчний чадвараас хөлийн хүчний чадварыг авч үзсэн бөгөөд 3 удаагийн харайлтаас хамгийн хол харайлтыг авсан.

Зураг 37.Хөлийн хүчний чадвар (см)



Хүүхдүүдийн гүйцэтгэл нас нэмэгдэх тусам охидын хувьд 3-4 насанд 21.5 см, 4-5 насанд 21.0 см -ээр нэмэгдсэн байна. Хөвгүүдийн хувьд 3-4 насанд 19.0 см, 4-5 насанд 14.4 см -ээр нэмэгдсэн байна.

Зураг 38. Охидын хөлийн хүчний чадвар бүсээр (см)




Охидын хөлийн хүчний чадвар бүсийн хувьд нас нэмэгдэх тусам өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 39. Хөвгүүдийн хөлийн хүчний чадвар бүсээр (см)



Хөвгүүдийн хөлийн хүчний чадвар бүсийн хувьд нас нэмэгдэх тусам өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 40. Судалгаа 1 ба Судалгаа 2 хөлийн хүчний чадварын үзүүлэлт (см)




Өмнөх судалгааны дундаж үзүүлэлтээс судалгаа 2-т хамрагдсан охид, хөвгүүдийн хөлийн хүчний чадвар хөвгүүдийн хувьд 4 насанд 9.9 см -р буурсан, 3 насанд 11.9 см, 5 насанд 7.5 см-ээр тус тус нэмэгдсэн байна. Охидын хувьд 3 насанд 8.7 см -ээр нэмэгдсэн, 4-5 насанд тогтвортой байна. Хоёр судалгааны үр дүнг харьцуулан үзэхэд хөлийн хүчний чадвар нас ахих тусам тогтвортой сайжирч байгаа бөгөөд хөвгүүд охидоос тогтмол давуу гүйцэтгэлтэй байна.

Тэсвэрийн чадвар

Тэсвэрийн чадвар нь хүүхдийн зүрх судасны тогтолцоо, булчингийн ачаалал даах чадамж, амьсгалын зохицуулалттай шууд холбоотой. Энэхүү чадвар нь дунд болон холын зайд гүйх сорилуудаар хэмжигддэг бөгөөд 200 м гүйлтийн гүйцэтгэл нь бага насны хүүхдийн тэсвэрийн түвшинг илэрхийлэх чухал үзүүлэлт юм.

Зураг 41. Тэсвэрийн чадварын үзүүлэлт насаар (сек)



Тэсвэрийн чадварыг хүүхдийн нас физиологийн онцлогын дагуу 3 насанд сорил аваагүй бөгөөд 4 ба 5 настай хүүхдийг 200м гүйлгэж туулсан хугацаагаар хэмжилт хийсэн болно. Хүүхдийн гүйцэтгэлээс хархад хөвгүүд бага хугацаанд хурдтай гүйсэн байна.

Зураг 42. Охидын тэсвэрийн чадвар (сек)



Төвийн, баруун, урд бүсийн хүүхдийн 200 м зайг туулах хугацаа нь буурч байна.

Зураг 43. Хөвгүүдийн тэсвэрийн чадвар бүсээр(сек)



Хөвгүүдийн хувьд төв, баруун, урд бүсийн 5 настай хүүхдийн гүйцэтгэл сайтай байгаа бол зүүн бүсийн 5 настай хөвгүүдийн, хойд бүсийн хүүхдийн гүйцэтгэл удаан байна. Холын зайг тэсвэртэйгээр амжилттай туулах чадвараар тэсвэрийн үзүүлэлтийг хэмжсэн бөгөөд хөвгүүдийн үзүүлэлт 4 насанд 3.2 секундээр 5 насанд 5.8 секундээр удааширсан, охидын үзүүлэлт 4 насанд 2.3 секундээр хурдан туулсан, 5 насанд 4.6 секундээр удааширсан байгаа нь бие бялдрын бэлтгэлжилтийн тэсвэрийн чадвар буурч байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 23.Хүүхдийн биеийн хөгжлийн үзүүлэлт ба хамаарал

	Хөлийн хүч	Толгойн тойрог	Биеийн жин	Биеийн өндөр	Цээжний тойрог
Хүйс	-.201**	-.265**			-.200**
СӨБ-д хамрагдсан жил	.473**	.247**	.375**	.508**	.306**

Хүүхдийн хөлийн хүч нь хүйстэй хамааралтай буюу хөвгүүд охидоос илүү гүйцэтгэлтэй байдаг байна. ($r=-.265^{**}$, $p<0.01$), Хүүдийн СӨБ-д хамрагдах тусам хөлийн хүч, толгойн тойрог, биеийн жин, биеийн өндөр, цээжний тойрог нэмэгддэг байна. ($r=.473^{**}$, $.306^{**}$ $p<0.01$),

Хүснэгт 24. Бэлтгэлжилтийн чадвар ба үндсэн мэдээлэл

Үзүүлэлт	Насаа мэддэг	Цэцэрлэгийн бүлгээ мэддэг	Эерэг сэтгэл хөдлөл
Хурд	-.233**		
Тэнцвэр	.174**	.175**	.222**
Хөлийн хүч	.300**	.302**	.281**
Биеийн өндөр	.222**	.233**	.278**

Хүснэгт 25.Бие бялдрын чадварууд ба танин мэдэхүйн хамаарал

Үзүүлэлт	Сонсоод тогтоох	Логиктой сэтгэх	Анхаарлаа төвлөрүүлэх	Анхаарлын шилжилт	Бодит дүрслэл 1	Бодит дүрслэл 2
Бие бялдрын бэлтгэлжилт						
Хурд	-.278**	-.265**	-.237**	-.210**	-.225**	-.339**
Тэнцвэр		.198**	.292**			.270**
Хөлийн хүч	.281**	.255**	.444**	.362**	.318**	.492**

Биеийн өсөлтийн чадварууд						
Биеийн жин	.191**	.258**	.366**	.312**	.346**	.376**
Биеийн өндөр	.225**	.339**	.474**	.412**	.377**	.430**
Цээжний тойрог	.232**	.271**	.268**	.226**	.313**	.304**

Бие бялдрын чадварууд болон танин мэдэхүйн сонсоод тогтоох чадвар, логик сэтгэхүй, анхаарлаа төвлөрүүлэх чадвар, бодит дүрслэлийн сэтгэхүйн чадварууд хоорондоо харилцан хамааралтай байна.

Дүгнэлт

- Судалгаанд хамрагдсан хүүхдийн биеийн өсөлтийн үзүүлэлт физиологийн хөгжлийн дагуу өсөлттэй явагдаж байна.
- Төвийн бүсийн хөвгүүд бие бялдрын хувьд хамгийн өндөр үзүүлэлттэй, харин зүүн бүсийн хөвгүүд хамгийн бага үзүүлэлттэй байна. Эцэг эх асран хамгаалагчдын хариултаар зүүн бүсийн хүүхдийн дунд гимнастикийн тэмцээнд оролцдоггүй гэж хариулсан нь энэ талын үйл ажиллагаа шаардлагатай дутмаг байгаатай холбоотой байж болох юм.
- Хойд бүсийн хүүхдийн үзүүлэлт стандарт хазайлт өндөр байгаа нь тухайн бүсийн хүүхдийн өсөлт ялгаа ихтэй байгааг илэрхийлнэ. Гурван настай хөвгүүдийн бие бялдрын үзүүлэлт бүсийн хувьд ялгаатай байна. Төвийн бүсийн хүүхдийн толгойн тойрог, биеийн жин, өндөр, цээжний болон бүсэлхийн тойргийн хувьд хамгийн өндөр үзүүлэлттэй байна.
- Судалгааны хоёр шатны үр дүнг харьцуулан үзэхэд 3–5 насны хүүхдийн биеийн өндөрт хөвгүүдийн хувьд 4 насанд биеийн өндөр мэдэгдэхүйц өссөн (106.3 см - 107.7 см) бол 3 болон 5 насанд харьцангуй тогтвортой буюу бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь өсөлтийн хурдац тухайн насанд харилцан адилгүй явагдаж байгааг харуулж байна.

Хурдны чадвар

- Нас ахих тусам гүйцэтгэлийн хугацаа багасч, хурд сайжирч байна.
- Баруун бүсийн охид хамгийн хурдан гүйцэтгэлтэй (2.6 сек).
- Хөвгүүдийн гүйцэтгэл тогтмол бус, судалгааны хооронд ялгаатай.

Уян хатан чадвар

- Охид хөвгүүдээс илүү уян чадварын үзүүлэлтэй байна.

Тэнцвэрийн чадвар

- Нас ахих тусам огцом сайжирч байгаа ч хүйсийн ялгаа судалгаанаас хамаарч өөрчлөгдөж байна.
- Судалгаа 1-д охид давуу, Судалгаа 2-д хөвгүүд зарим насанд илүү гүйцэтгэлтэй.

Хөлийн хүч (байрнаас уртад харайлт)

- Хөвгүүд бүх насанд охидоос илүү гүйцэтгэлтэй.
- Нас ахих тусам тогтвортой сайжирч, ялгаа багасах хандлагатай.

Тэсвэр (200 м гүйлт)

- Хөвгүүд аль ч насанд тодорхой зайг хурдтай туулах чадвар сайтай байна.
- Хүүхдийн нас нэмэгдэх тусам бие бялдрын чадваруудын гүйцэтгэл нэмэгдэж байгаа ба ялангуяа 5 насанд гүйцэтгэл илт нэмэгддэг.
- Хүйсийн хувьд ялгаатай байна. Тухайлбал: охидын уян хатан, тэнцвэрт байдал гүйцэтгэл сайтай бол; хөвгүүдийн хурд, хөлийн хүч, тэсвэрт чадварууд гүйцэтгэл сайтай байна.

1.2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН ТАНИН МЭДЭХҮЙН ХӨГЖИЛ

Сургуулийн өмнөх боловсролын 3–5 насны хүүхдийн танин мэдэхүйн хөгжил нь хүүхдийн сурч боловсрох, нийгэмд оролцох суурь чадваруудыг төлөвшүүлэх чухал үе юм. Юмсыг ажиглах чадвар нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн суурь үзүүлэлт бөгөөд орчныг бүхэлд нь хүлээн авах, анхаарал төвлөрүүлэх, дүрслэх сэтгэлгээ, мэдээллийг боловсруулах чадамжтай холбоотой. Энэхүү судалгаанд 3–5 насны хүүхдүүдэд “зурагт дутуу зурагдсан зүйлийг олох” даалгавар өгч, гүйцэтгэлийн хугацаагаар үнэлж, 5 түвшинд ангилан бүс, насны харьцуулалт хийв.

1.2.1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭЖ АВАХ ЧАДВАР (АНХААРАЛ, ХҮРТЭХҮЙ, ОЙ ТОГТООЛТ)

Хүснэгт 26. Мэдээллийг хүлээн авах чадваруудын статистик үзүүлэлт

Чадварууд	N	Дундаж	Ст.хазайлт	Ст.хазайлт	Итгэх муж		Хамгийн бага	Хамгийн их	Levene	F утга	
					Доод	Дээд					
Ажигч чадвар	3 нас	84	1.440	1.0454	0.1141	1.214	1.667	1.0	5.0	21.163	11.862 **
	4 нас	84	1.786	1.3890	0.1516	1.484	2.087	1.0	5.0		
	5 нас	84	2.429	1.5232	0.1662	2.098	2.759	1.0	5.0		
	Нийт	252	1.885	1.3910	0.0876	1.712	2.057	1.0	5.0		
Сонорын ой	3 нас	84	1.917	0.5851	0.0638	1.790	2.044	1.0	3.0	11.444	23.768 **
	4 нас	84	1.964	0.6845	0.0747	1.816	2.113	1.0	4.0		
	5 нас	84	2.583	0.8097	0.0883	2.408	2.759	1.0	4.0		
	Нийт	252	2.155	0.7600	0.0479	2.060	2.249	1.0	4.0		
Анхаарлын тогтворжилт	3 нас	84	2.357	0.8308	0.0906	2.177	2.537	1.0	5.0	3.780	71.190 **
	4 нас	84	3.274	1.0794	0.1178	3.040	3.508	1.0	5.0		
	5 нас	84	4.143	0.9835	0.1073	3.929	4.356	2.0	5.0		
	Нийт	252	3.258	1.2112	0.0763	3.108	3.408	1.0	5.0		
Харж тогтоох	3 нас	84	3.131	1.1170	0.1219	2.889	3.373	1.0	5.0	1.486	10.239 **
	4 нас	84	3.429	1.0787	0.1177	3.194	3.663	1.0	5.0		
	5 нас	84	3.869	0.9913	0.1082	3.654	4.084	1.0	5.0		
	Нийт	252	3.476	1.1021	0.0694	3.339	3.613	1.0	5.0		

Хүүхдүүдийн ажиглах чадварын дундаж оноо (Дундаж=1.44) харьцангуй сул түвшинд байна. (Медиан=1.00) Ихэнх хүүхэд 1 оноо авсан, дундажтай ойролцоо, стандарт хазайлт (S. D = 1.05) их байгаа нь зарим хүүхэд илүү сайн ажиглах чадвартай байгааг харуулж байна. Онооны тархалтын хэмжээ буюу хувьсах чанар их, хүүхдийн чадвар ялгаатай байна. (Variance = 1.09) тархалт нэлээд өргөн байна, Range=4.0 (Min=1.0, Max=5.0) Хамгийн бага ба их онооны зөрүү хүүхдийн гүйцэтгэх чадвар ялгаатай байна.

Хүснэгт 27. Чадваруудын дундаж үзүүлэлт

Чадвар	Дундаж оноо	Тайлбар
Ажигч чадвар	1.44	Хүүхдийн ажигч байдал харьцангуй сул
Сонсож тогтоох	1.92	Сонссон мэдээллийг тогтоох чадвар сул
Анхаарлын тогтворжилт	2.36	Анхаарлаа төвлөрүүлж хадгалах чадвар дунд түвшинд.
Анхаарлын шилжилт	3.24	Хүүхдүүд анхаарлаа нэг зүйлээс нөгөөд шилжүүлэхэд сайн.


Харааны ой тогтоолт	3.13	Хараагаар харсан зүйлсийг тогтоох чадвар харьцангуй сайн.
---------------------	------	---

Харааны ой тогтоолт нь 3 настай хүүхдийн хувьд хамгийн сайн гүйцэтгэлтэй чадвар байна. Ажигч чадвар, сонсож тогтоох чадвар 5 насанд “Өндөр” болон “Маш өндөр” түвшний хувь баруун, зүүн бүсэд гүйцэтгэл сайтай байна.

Төвийн бүс нь 5 насанд “Өндөр” түвшинд 30.6 хувь нь хүрсэн ч “Маш хангалтгүй” түвшин 41.7 хувь хэвээр байгаа нь хүүхдийн гүйцэтгэл ялгаа ихтэй байгааг харуулж байна. Урд бүс нь бүх насанд “Маш хангалтгүй” түвшинд байна.


Юмсыг ажиглах чадвар нь танин мэдэхүйн хөгжлийн суурь үзүүлэлт бөгөөд орчныг таних, анхаарал төвлөрүүлэх, мэдээллийг бүхэлд нь хүлээн авах чадамжтай холбоотой. Судалгааны үр дүнгээс харахад: Нас ахих тусам ажиглалтын чадвар сайжирч байгаа ч бүсийн ялгаатай байдал ажиглагдаж байна. Баруун болон зүүн бүсүүд нь 5 насанд “Өндөр” болон “Маш өндөр” түвшинд илүү хувьтай байгаа нь ажиглалтын чадвар насны онцлогтой нэмэгдэж байна.

Зураг 44. Хүүхдийн юмсыг ажиглах чадварын түвшин



Судалгаанд хамрагдсан хүүхэд нас ахих тусам маш хангалтгүй үнэлгээ буурч, өндөр болон маш өндөр үнэлгээ нэмэгдэж байгаа нь ажиглах чадвар нас нэмэгдэх тусам сайжирч байгааг харуулж байна. 3 настай хүүхдийн 81.0 хувь нь маш хангалтгүй үнэлгээтэй ажиглах чадвар нь сул байна. 4 настай хүүхдийн 20.2 хувь нь өндөр, маш өндөр түвшинд болж нэмэгдсэн байна. Харин 5 настай хүүхдийн хувьд маш хангалтгүй түвшинд 47.5 хувь нь даалгавар гүйцэтгэсэн бол өндөр, маш өндөр түвшинд 35.7 хувь болж нэмэгдсэн байна. СӨБ-ын 3-4 настай хүүхдийн юмсыг ажиглах чадварыг дэмжих сургалтын орчин бүрдүүлэх, үйл ажиллагаа шаардлагатай байгаа бол 4–5 настай хүүхдийг тодорхой зорилготой ажиглалт хийлгэх, харьцуулалт хийх дасгал ажиллуулж дэмжих хэрэгтэй.

Зураг 45. Хүүхдийн юмсыг ажиглах чадвар зураг тус бүрээр



Хүүхдийн гүйцэтгэл нас нэмэгдэх тусам жигд гүйцэтгэлтэй болж дутуу зурагдсан зүйлийг олж харж байгаа ч 4 ба 3 настай хүүхдүүд сүүлийн зурагт байгаа дутуу зүйлийг хамгийн бага хувьтай олсон байна.

Хүснэгт 28. Юмсыг ажиглах чадвар нас ба бүсээр

Бүс	Төвийн бүс			Хойд бүс			Баруун бүс			Урд бүс			Зүүн бүс		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Маш хангалтгүй	86.1	75.0	41.7	100.0	100.0	41.7	66.7	41.7	33.3	100.0	91.7	58.3	41.7	41.7	25.0
Хангалтгүй	2.8	5.6	8.3	0.0	0.0	8.3	8.3	8.3	0.0	0.0	8.3	8.3	33.3	16.7	8.3
Дундаж	2.8	0.0	8.3	0.0	0.0	8.3	8.3	0.0	8.3	0.0	0.0	16.7	0.0	8.3	16.7
Өндөр	2.8	8.3	30.6	0.0	0.0	30.6	8.3	25.0	33.3	0.0	0.0	16.7	25.0	33.3	41.7
Маш өндөр	5.6	11.1	11.1	0.0	0.0	11.1	8.3	25.0	25.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	8.3

Бүсүүдээр авч үзэхэд

Төвийн бүсийн хувьд:

Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдийн 86.1 хувь нь маш хангалтгүй түвшинд байгаа ба нас нэмэгдэх тусам энэ түвшинд байгаа хувь буурч маш өндөр түвшин нэмэгдэж байгаа нь 3 настай хүүхдийн хувьд дэмжлэг шаардлагатай байгааг илэрхийлж байна.

Хойд бүсийн хувьд:

Судалгаанд хамрагдсан 3-4 насны хүүхдүүд бүгд маш хангалтгүй түвшинд байгаа нь энэ чадварыг хөгжүүлэх сургалт зайлшгүй шаардлагатай байгааг илэрхийлж байна. Харин 5 настай хүүхдийн гүйцэтгэл өндөр, маш өндөр түвшинд 41.7 хувь болж нэмэгдсэн байна. Юмсыг ажиглах чадвар 5 насанд гүйцэтгэл сайжирч байгаа ч 3-4 насанд сургалтаар дэмжих.

Урд бүсийн хувьд:

Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдүүд бүгд маш хангалтгүй түвшинд гүйцэтгэсэн ба 5 настай хүүхдийн 16.7 хувь нь өндөр түвшинд гүйцэтгэлтэй байгаа ба энэ бүсийн хүүхдийн ажигч чадвар бусад бүсээс хоцрогдолтой байна.


Зүүн бүсийн хувьд:

Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдийн 41.7 хувь нь маш хангалтгүй түвшинд гүйцэтгэсэн ба 5 настай хүүхдийн 50.0 хувь нь өндөр, маш өндөр түвшинд гүйцэтгэл өндөр байна.

Богино хугацааны хараа, сонорын ой тогтоолт

Ой тогтоолт нь сургуулийн өмнөх насны хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн суурь үзүүлэлт бөгөөд сонсоод мэдээллийг хүлээн авах, хадгалах, сэргээн санах чадамжтай холбоотой. Энэхүү судалгаанд 3-5 насны хүүхдүүдэд 10 үг сонсгоод тогтоох даалгавар өгч, гүйцэтгэлийг 5 түвшинд ангилан бүс, насны харьцуулалт хийв.

Зураг 46. Сонсож тогтоох чадвар



Хүүхдийн сонсоод тогтоох чадварын гүйцэтгэл хангалтгүй байгаа ч нас нэмэгдэх тусам сайжирч байна. Нас ахих тусам “Маш хангалтгүй” болон “Хангалтгүй” түвшний хувь буурч, “Дундаж” болон “Өндөр” түвшний хувь нэмэгдэж байна. Жишээлбэл, 5 насанд “Маш хангалтгүй” 0.6 хувь, “Дундаж” 35.7 хувь, “Өндөр” 14.3 болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 29. Сонсоод тогтоох чадварын гүйцэтгэл, нас бүсээр


	Төвийн бүс			Хойд бүс			Баруун бүс			Урд бүс			Зүүн бүс		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Маш хангалтгүй	13.9	16.7	0.0	33.3	16.7	0.0	25.0	8.3	8.3	16.7	58.3	33.3	33.3	25.0	0.0
Хангалтгүй	69.4	66.7	36.1	50.0	83.3	50.0	58.3	50.0	25.0	83.3	33.3	50.0	58.3	58.3	75.0
Дундаж	16.7	13.9	50.0	16.7	0.0	50.0	16.7	33.3	25.0	0.0	8.3	8.3	8.3	16.7	16.7
Өндөр		2.8	13.9		0.0	0.0		8.3	41.7		0.0	8.3		0.0	8.3

Бүсийн ялгаа: Сонсоод тогтоох чадвар нас ахих тусам сайжирч байгаа ч бүсийн хувьд ялгаатай байна. Баруун бүсийн 5 настай хүүхдүүд хамгийн сайн гүйцэтгэлтэй гарсан бол зүүн болон урд бүсүүд нь 4–5 насанд мөн “Хангалтгүй” түвшинд өндөр хувьтай байна.

- Баруун бүсийн 5 нас: “Өндөр” түвшин 41.7 хувь нь буюу хамгийн сайн гүйцэтгэлтэй бүс.
- Урд бүсийн 4 нас: “Маш хангалтгүй” түвшинд 58.3 хувь, “Хангалтгүй” түвшинд 33.3 хувь байгаа нь сул гүйцэтгэлтэй бүс
- Зүүн бүсийн 5 нас: “Хангалтгүй” 75.0 хувь байгаа нь зайлшгүй дэмжих шаардлагатай


Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөрийн “Танин мэдэхүйн хөгжил” чиглэлд дараах зорилгууд тусгагдсан: Сонсоод мэдээллийг хүлээн авах, ойлгох, сэргээн санах, анхаарал төвлөрөл, ой тогтоолт, логик сэтгэлгээг хөгжүүлэх, асуулт тавих, дүгнэлт хийх, мэдээллийг боловсруулах эдгээр зорилгууд нь 10 үгийн даалгаврын гүйцэтгэлтэй шууд уялдаж байна.

Зураг 47. Сонорын ой тогтоолт



Хүүхдүүд наснаас хамаарахгүйгээр багшийн хэлү буй утгын холбоогүй 10 үгээс хэлж буй эхэнд хэлсэн үг буюу мод, 5 дахь үг, 10 дахь машин гэдэг үгийг хамгийн өндөр хувьтай тогтоосон бол 3 дахь сэрээ, 8 дахь зураг гэх үсгийг хамгийн бага хувьтай тогтоосон байна. Нас болгонд тогтоосон үгийн мурийлт адилхан байна.

Зураг 48. Нийт насаар сонорын ой тогтоолт




Судалгаанд хамрагдсан хүүхдүүд мод, цэцэг, машин, ном гэсэн үгсийг хамгийн өндөр хувьтай тогтоосон бөгөөд сэрээ, зураг, хүн гэсэн үгсийг хамгийн бага хувьтай тогтоосон байна.

Анхаарал

Анхаарлаа тогтворжуулах чадвар

Тодорхой юмс үзэгдэл, үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар анхаарлаа төвлөрүүлэх чадварыг гүйцэтгэлээр нь авч үзлээ.

Зураг 49. Анхаарлын тогтворжилт гүйцэтгэл насаар



Нэг зүйлд анхаарлаа тогтворжуулан үйлдэл хийх чадвар нас нэмэгдэх тусам сайжирсан байна. Хангалттай, маш хангалттай түвшинд 3 насны хүүхдийн 4.8 хувь, 4 насны хүүхдийн 39.4 хувь, 5 насны хүүхдийн 70.2 хувь нь маш өндөр түвшинд даалгавар гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 30. Анхаарлын тогтворжилт бүсээр

Нас	Төвийн бүс			Хойд бүс			Баруун бүс			Урд бүс			Зүүн бүс		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Маш хангалтгүй	0.0	2.8		75.0	8.3		8.3	0.0	16.7	8.3	0.0		16.7	0.0	
Хангалтгүй	47.2	11.1	2.8	0.0	41.7	8.3	58.3	33.3		58.3	50.0	0.0	16.7	8.3	8.3
Дундаж	44.4	41.7	13.9	16.7	25.0	33.3	33.3	41.7	41.7	33.3	33.3	33.3	66.7	16.7	16.7
Өндөр	8.3	22.2	11.1	0.0	16.7	25.0	0.0	25.0	25.0	0.0	8.3	25.0	0.0	41.7	33.3
Маш өндөр	0.0	22.2	72.2	8.3	8.3	33.3	0.0	0.0	16.7	0.0	8.3	41.7	0.0	33.3	41.7

Баруун бүсийн хүүхдийн гүйцэтгэл хамгийн бага буюу 4 насанд 25.0 хувь, 5 насанд 41.7 хувь байгаа бол төвийн бүсийн хүүхдийн гүйцэтгэл хамгийн өндөр хувьтай гүйцэтгэсэн байна.

1.2.2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН СЭТГЭХҮЙ, ХЭЛ ЯРИАНЫ ЧАДВАР

Хүүхдийн сэтгэхүй, хэл ярианы чадвар нь логик зүй тогтолт сэтгэлгээ, дүгнэлт хийх, мэдээллийг нэгтгэх, шалтгаан-үр дагаврыг ойлгох чадамжуудыг илэрхийлдэг бөгөөд танин мэдэхүйн хөгжлийн түвшинг илэрхийлдэг. Харьцуулах, нэгтгэн дүгнэх чадвар нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн түвшнийг илэрхийлэх чадамж бөгөөд логик сэтгэлгээ, мэдээллийг задлан шинжлэх, шалтгаан-үр дагаврыг ойлгох, дүгнэлт гаргах зэрэг сэтгэхүйн үйл ажиллагаатай холбоотой. Энэхүү судалгаанд 3-5 насны хүүхдийн гүйцэтгэлийг таван түвшингээр бүсээр, насаар харьцуулалт хийж үзэв.

Хүснэгт 31. Логиктой сэтгэх чадварын статистик үзүүлэлт

N	Дундаж	Ст.хазайлт	Ст.хазайлт	Итгэх		Хамгийн бага	Хамгийн их	Levene	F утга
				мужДоод	ДундажДээд				
3 нас	84	3.286	1.3494	0.1472	2.993	3.579	1.0	5.0	

4 нас	84	3.881	0.9494	0.1036	3.675	4.087	1.0	5.0	27.031	30.010 **
5 нас	84	4.500	0.6111	0.0667	4.367	4.633	2.0	5.0		
Нийт	252	3.889	1.1272	0.0710	3.749	4.029	1.0	5.0		

Хүснэгт 32. Сэтгэхүй ба хэл ярианы статистик үзүүлэлт

Чадварууд	Нас	Дундаж	Ст.хазайлт	95хувь итгэх муж		Ст.хазайлт	Хамгийн бага	Хамгийн их	F
				Дундаж					
				Доод	Дээд				
Логиктой сэтгэх чадвар	3 нас	3.875	0.3504	3.046	4.704	0.9910	2.0	5.0	30.010 **
	4 нас	3.933	0.2063	3.491	4.376	0.7988	2.0	5.0	
	5 нас	4.636	0.1521	4.297	4.975	0.5045	4.0	5.0	
Сэтгэхүйн харьцуулан ангилах чадвар	3 нас	4.000	0.2673	3.368	4.632	0.7559	3.0	5.0	28.913 **
	4 нас	4.000	0.2760	3.408	4.592	1.0690	2.0	5.0	
	5 нас	4.636	0.2787	4.015	5.257	0.9244	2.0	5.0	
Сэтгэхүйн нэгтгэн дүгнэх чадвар	3 нас	3.875	0.2950	3.177	4.573	0.8345	3.0	5.0	38.828 **
	4 нас	3.400	0.1902	2.992	3.808	0.7368	2.0	5.0	
	5 нас	4.091	0.2113	3.620	4.562	0.7006	3.0	5.0	
Хэл ярианы чадвар	3 нас	23.625	3.8773	14.457	32.793	10.9667	5.0	35.0	18.726 **
	4 нас	29.133	2.8467	23.028	35.239	11.0251	11.0	50.0	
	5 нас	24.182	2.1227	19.452	28.911	7.0401	14.0	39.0	
Дүгнэсэн өгүүлбэр	3 нас	1.000	0.1890	0.553	1.447	0.5345	0.0	2.0	3.433 **
	4 нас	1.067	0.0667	0.924	1.210	0.2582	1.0	2.0	
	5 нас	1.000	0.0000	1.000	1.000	0.0000	1.0	1.0	

Сэтгэхүй ба хэл ярианы статистик үзүүлэлтүүд хоорондоо харилцан хамааралтай бие биенээ дэмжиж хөгждөг байна.

Логиктой сэтгэх чадвар

Хүүхдэд байрлал нь алдагдсан зураг үзүүлэн байрлалыг зөв байрлуулах дасгал 3 минутын хугацаанд гүйцэтгүүлсэн.

Зураг 50. Логиктой сэтгэх чадвар



Хүүхдийн логиктой сэтгэх чадвар нас нэмэгдэх тусам сайжирсан буюу дунджаас дээш түвшинд гүйцэтгэл нэмэгдсэн байна. Гурван настай хүүхдийн 51.2 хувь, 4 настай хүүхдийн 86.2 хувь, 5 настай хүүхдийн 96.5 хувь нь маш өндөр, өгдөр түвшинд даалгавар гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 33. Логиктой сэтгэх чадвар бүс, насаар


	Төвийн бүс			Хойд бүс			Баруун бүс			Урд бүс			Зүүн бүс		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Маш хангалтгүй	5.6	0.0		33.3	8.3	8.3	25.0	8.3		16.7	8.3		8.3	0.0	
Хангалтгүй	8.3	0.0	0.0	58.3	16.7	8.3	0.0	8.3	0.0	16.7	8.3	0.0	8.3	0.0	0.0
Дундаж	25.0	11.1	0.0	0.0	33.3	58.3	25.0	8.3	0.0	8.3	16.7	8.3	25.0	16.7	0.0
Өндөр	30.6	55.6	22.2	0.0	41.7	25.0	16.7	33.3	33.3	41.7	58.3	66.7	58.3	66.7	66.7
Маш өндөр	30.6	33.3	77.8	8.3	0.0		33.3	41.7	66.7	16.7	8.3	25.0	0.0	16.7	33.3

Хүүхдийн юмс үзэгдлийг логик зүй тогтолын дагуу сэтгэх чадвар нь төвийн (77.8 хувь), баруун (66.7 хувь) 5 настай хүүхдийн гүйцэтгэл хамгийн өндөр хувьтай байгаа ба хойд бүсэд амьдарч буй хүүхдийн гүйцэтгэл хамгийн бага байгааг дэмжих.

Сэтгэхүйн харьцуулан ангилах чадвар

СӨБ-ын хүүхдийн сэтгэхүйн харьцуулан ангилах чадвар нь танин мэдэхүйн хөгжлийн чухал хэсэг бөгөөд хүүхэд энэ насандаа аливаа зүйлсийн өнгө, хэлбэр, хэмжээ, зориулалтаар нь ялгаж, ангилах байдлаар хөгжлийг нь дэмжиж болно. Энэ чадвар нь хүүхдийн **логик сэтгэлгээ, ангилах, бүлэглэх, харьцуулах, дүгнэх** чадамжуудыг илэрхийлдэг бөгөөд танин мэдэхүйн хөгжлийн гол үзүүлэлт юм. Энэхүү судалгаанд 3–5 насны хүүхдийн гүйцэтгэлийг таван түвшинд ангилан бүс, насны харьцуулалт хийв.

Зураг 51. Сэтгэхүйн харьцуулан ангилах чадварын гүйцэтгэл насаар.



Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдийн гүйцэтгэл 39.3 хувь, 4 насанд 63.1 хувь болж нэмэгдсэн нь зүй тоглолын дагуу хөгжиж байгааг харуулж байна. Нас нэмэгдэх тусам “Маш хангалтгүй” болон “Хангалтгүй” түвшний хувь буурч, “Маш өндөр” түвшин нэмэгдэж байна. Жишээлбэл, Төвийн бүсийн 5 насанд “Маш өндөр” 84.5 хувь хүрсэн нь хамгийн өндөр гүйцэтгэлтэй насны бүлэг байна.


Хүснэгт 34. Сэтгэхүйн харьцуулан ангилах чадварын гүйцэтгэл бүс, насаар

	Төвийн бүс			Хойд бүс			Баруун бүс			Урд бүс			Зүүн бүс		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Маш хангалтгүй	13.9	0.0	0.0	50.0	0.0	16.7	16.7	8.3	0.0	16.7	16.7	0.0	33.3	8.3	0.0
Хангалтгүй	22.2	5.6	2.8	16.7	25.0	25.0	0.0	8.3	0.0	33.3	16.7	16.7	16.7	0.0	0.0
Дундаж	25.0	25.0	0.0	16.7	50.0	25.0	25.0	16.7	8.3	8.3	8.3	0.0	8.3	8.3	8.3
Өндөр	13.9	19.4	2.8	16.7	16.7	25.0	25.0	25.0	25.0	8.3	25.0	25.0	33.3	50.0	25.0
Маш өндөр	25.0	50.0	94.4	0.0	8.3	8.3	33.3	41.7	66.7	33.3	33.3	58.3	8.3	33.3	66.7

Төвийн бүсийн 5 настай хүүхдийн гүйцэтгэл “Маш өндөр” 94.4, хойд бүсийн 5 настай хүүхдийн гүйцэтгэл 8.3 хувь “Маш өндөр” түвшинд байгаа нь дэмжих шаардлагатайг илэрхийлж байна. Зүүн болон баруун бүсийн хүүхдийн гүйцэтгэл нас нэмэгдэх тусам өссөж байна.

Сэтгэхүйн харьцуулан ангилах чадвар нь нас ахих тусам гүйцэтгэл сайжирч байгаа бөгөөд 5 насанд “Маш өндөр” түвшинд гүйцэтгэл бүс бүрт нэмэгдэж байна.

Зураг 52. Сэтгэхүйн харьцуулах, нэгтгэн дүгнэх чадвар



Судалгаанд хамрагдсан хүүхдүүд юмсыг харьцуулах, нэгтгэн дүгнэх нь нас нэмэгдэх тусам гүйцэтгэл “Өндөр” түвшинд сайжирч байна.

Хүснэгт 35. Сэтгэхүйн харьцуулах нэгтгэн дүгнэх чадвар

	Төвийн бүс			Хойд бүс			Баруун бүс			Урд бүс			Зүүн бүс		
	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас	3 нас	4 нас	5 нас
Маш хангалтгүй	8.3	0.0		25.0	8.3		8.3	0.0		8.3	0.0		16.7	0.0	
Хангалтгүй	8.3	5.6	0.0	33.3	8.3	8.3	0.0	0.0	8.3	8.3	50.0	0.0	0.0	0.0	0.0
Дундаж	63.9	50.0	25.0	25.0	58.3	16.7	58.3	66.7	16.7	83.3	50.0	25.0	75.0	58.3	8.3
Өндөр	19.4	38.9	52.8	16.7	25.0	33.3	25.0	25.0	33.3	0.0	0.0	41.7	0.0	33.3	41.7
Маш өндөр	0.0	5.6	22.2	0.0	0.0	41.7	8.3	8.3	41.7	0.0	0.0	33.3	8.3	8.3	50.0

Бүсийн ялгаа:

Баруун бүсийн 4 настай хүүхдийн 66.7 хувь нь “Дундаж” түвшинд гүйцэтгэлтэй


Зүүн бүсийн 5 нас: “Өндөр” 41.7 хувь нь— гүйцэтгэл сайтай

Урд бүсийн 3 нас: “Дундаж” 83.3 — маш сайн үзүүлэлт

Хойд бүсийн 3 нас: “Маш хангалтгүй” 25.0, “Хангалтгүй” 33.3 хувь нь хамгийн сул гүйцэтгэлтэй бүс байна.


Сэтгэхүйн харьцуулах, нэгтгэн дүгнэх чадвар нь нас ахих тусам мэдэгдэхүйц сайжирч байгаа бөгөөд 5 насанд “Өндөр” түвшинд хүрсэн хүүхдийн хувь бүс бүрт нэмэгдэж байна. Төвийн бүсийн 5 нас хамгийн өндөр гүйцэтгэлтэй бол хойд бүсийн 3 нас хамгийн сул байна.

Зураг 53. Хэл ярианы чадвар санаагаа 1-2 өгүүлбэрээр илэрхийлсэн байдал




Зураг харж санаагаа 1-2 өгүүлбэрээр илэрхийлсэн хүүхдийн хувьд 3 настай хүүхдийн 55.6 хувь нь 2 өгүүлбэрээр, 4 настай хүүхдийн 20.0 хувь нь 3 өгүүлбэрээр, 5 настай хүүхдийн 80.0 хувь нь 2 өгүүлбэрээр санаагаа илэрхийлсэн байна.

Зураг 54. Хэл ярианы чадвар санаагаа 3-4 өгүүлбэрээр илэрхийлсэн байдал



Зураг харж санаагаа 3-4 өгүүлбэрээр илэрхийлсэн хүүхдийн хувьд 3 настай хүүхдийн 47.6 хувь нь 4 өгүүлбэрээр, 4 настай хүүхдийн 60.6 хувь нь, 5 настай хүүхдийн 60.7 хувь нь 4 өгүүлбэрээр санаагаа илэрхийлсэн байна.

Зураг 55. Хэл ярианы чадвар санаагаа 5 дээш өгүүлбэрээр илэрхийлсэн байдал




Зураг харж санаагаа 5-аас дээш өгүүлбэрээр илэрхийлсэн хүүхдийн хувьд 3 настай хүүхдийн 4.0 хувь нь 7 – оос дээш өгүүлбэрээр, 4 настай хүүхдийн 3.7 хувь нь, 5 настай хүүхдийн 15.5 хувь нь 7-оос дээш өгүүлбэрээр санаагаа илэрхийлсэн байна.

Зураг 56. Санаагаа илэрхийлсэн хугацаа




Зураг харж санаагаа илэрхийлэхдээ хүүхдүүд 101.62 сек буюу 1 минут 70 сек зарцуулсан бол 5 настай хүүхдүүд 1 минут 64 секунд, 4 насад 1.76 секунд, 3 насанд 1 минут 68 секунд зарцуулсан байна.

Зураг 57. Санаагаа өгүүлбэрээр илэрхийлсэн байдал Судалгаа 1 ба судалгаа 2



Судалгаа 1 ба судалгаа 2 хувьд хүүхдийн 5-6 энгийн өгүүлбэрээр санаагаа илэрхийлэх болон 7-оос дээш энгийн өгүүлбэрээр санаагаа илэрхийлэх өгүүлбэрийн тоо нэмэгдсэн байна.

Зураг 58. Хүүхдийн идэвхтэй үгийн нөөц



Хүүхдүүд судалгаа 1 -д санаагаа дунджаар 26 үгээр илэрхийлж байсан бол судалгаа 2 т 22 идэвхтэй үг ашиглан санаагаа илэрхийлсэн байна.

Хүснэгт 36. Санаагаа илэрхийлсэн үгийн тоо

	3 нас	4 нас	5 нас	нийт
1-10 үг	30.9	9.6	6.0	15.2
11-20 үг	32.1	39.6	32.3	34.4
21-30 үг	27.1	24.0	35.9	28.8
31-40 үг	9.9	20.4	13.2	14.4
41-55 үг	0.0	7.2	13.2	6.8

Хүүхдийн нас нэмэгдэх тусам санаагаа илэрхийлж буй үгийн тоо нэмэгддэг байна. Нийт хүүхдийн 15.2 хувь нь 10 хүртэлх үгээр, 11-20 үгээр 34.4 хувь, 21-30 үгээр 28.8 хувь, 31-40 үгээр 14.4 хувь, 41-55 хүртэлх үгээр 6.8 хувь нь санаагаа илэрхийлжээ.

Дүгнэлт

Сургуулийн өмнөх боловсролын 3-5 насны хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн онцлогийг мэдээллийг хүлээж авах чадвар буюу ажиглах чадвар, анхаарал, хүртэхүй, ой тогтоолтын чадваруудаар, сэтгэхүй, хэл ярианы чадваруудыг авч үзлээ.

Мэдээллийг хүлээн авах чадвар

- Юмсыг ажиглах чадвар тухайлбал 3 настай хүүхдийн 81.0 хувь, 5 настай хүүхдийн 47.6 хувь нь маш хангалтгүй түвшинд байгаа нь энэ чадварыг дэмжих шаардлага байгааг илэрхийлж

байна. хүүхдийн гүйцэтгэлийн хамгийн бага ба их оноо зөрүү ихтэй байгаа нь хүүхдийн даалгавар гүйцэтгэх чадвар ялгаа байгааг илэрхийлж байна.

- Тодорхой нэг зүйлд анхаарлаа тогтворжуулан үйлдэл хийх чадвар нас нэмэгдэх тусам сайжирсан байна.
- Анхаарлын шилжилт, харааны ой тогтоолт нь 3 настай хүүхдийн хувьд хамгийн сайн гүйцэтгэлтэй чадварууд байна
- Тодорхой нэг зүйлд анхаарлаа тогтворжуулан үйлдэл хийх чадвар нас нэмэгдэх тусам сайжирсан байна. Хангалттай, маш хангалттай түвшинд 3 насны хүүхдийн 4.8 хувь, 4 насны хүүхдийн 39.4 хувь, 5 насны хүүхдийн 70.2 хувь нь маш өндөр түвшинд даалгавар гүйцэтгэсэн байна.
- Хүүхдүүд наснаас хамаарахгүйгээр багшийн хэлж буй утгын холбоогүй 10 үгээс хэлж буй эхэнд хэлсэн үг буюу мод, 5 дахь үг, 10 дахь машин гэдэг үгийг хамгийн өндөр хувьтай тогтоосон бол 3 дахь сэрээ, 8 дахь зураг гэх үсгийг хамгийн бага хувьтай тогтоосон байна. Нас болгонд тогтоосон үгийн мурийлт адилхан байна.

Мэдээллийг хүлээн авах чадвар бүсээр

Төвийн бүсийн хувьд:

- Юмсыг ажиглах чадвар төвийн бүсийн хүүхдийн хувьд 5 насанд 30.6 хувь нь “Өндөр” түвшинд гүйцэтгэсэн, нийт хүүхдийн гүйцэтгэлд ялгаа их байна.
- Төвийн бүсийн хүүхдийн анхаарлын тогтворжилтыг дэмжих
- Сонсоод тогтоох чадвар энэ бүсийн хүүхдийн хувьд гүйцэтгэл сайтай, 4-5 насанд бусад бүсээс 16.7 хувь нь өндөр түвшинд гүйцэтгэлтэй байна.

Хойд бүсийн хувьд:

- Судалгаанд хамрагдсан хойд бүсийн 3-4 насны хүүхдийн юмсыг ажиглах чадвар бүгд маш хангалтгүй түвшинд байна. Харин 5 настай хүүхдийн гүйцэтгэл өндөр, маш өндөр түвшинд 41.7 хувь болж нэмэгдсэн байна. Юмсыг ажиглах чадвар 5 насанд гүйцэтгэл сайжирч байгаа ч 3-4 насанд сургалтаар дэмжих шаардлагатай.
- Хүүхдүүдийн анхаарлын тогтворжилт 4, 5 насанд хамгийн өндөр гүйцэтгэлтэй байна.
- Сонсоод тогтоох чадварыг дундажаас дээш түвшинд гүйцэтгэл байхгүй учир дэмжих шаардлагатай

Урд бүсийн хувьд:

- Юмсыг ажиглах чадвар урд бүсийн судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдийн хувьд бүгд маш хангалтгүй түвшинд гүйцэтгэсэн ба 5 настай хүүхдийн 16.7 хувь нь өндөр түвшинд гүйцэтгэлтэй байгаа ба энэ бүсийн хүүхдийн ажигч чадвар бусад бүсээс хоцрогдолтой байна.
- Анхаарлын тогтворжилтийг 3-4 насанд насны онцлогт тохирсон даалгавар гүйцэтгүүлж дэмжих
- Сонсоод тогтоох чадвар урд бүсийн 4 настай хүүхдийн гүйцэтгэл “Маш хангалтгүй” түвшинд 58.3 хувь, “Хангалтгүй” түвшинд 33.3 хувь байгаа нь сул гүйцэтгэлтэй байгаа тул дэмжих

Зүүн бүсийн хувьд:

- Судалгаанд хамрагдсан зүүн бүсийн 3 настай хүүхдийн юмсыг ажиглах чадвар 41.7 хувь нь маш хангалтгүй түвшинд гүйцэтгэсэн ба 5 настай хүүхдийн 50.0 хувь нь өндөр, маш өндөр түвшинд гүйцэтгэл өндөр байна. 3-4 настай хүүхдийн энэ чадварыг дэмжих
- 4, 5 настай хүүхдийн анхаарлын тогтворжилт гүйцэтгэл сайн, 3 насанд дэмжих
- Сонсоод тогтоох чадвар зүүн бүсийн 5 настай хүүхдийн хувьд “Хангалтгүй” 75.0 хувь байгаа нь энэ чадварыг зайлшгүй дэмжих шаардлагатай байна.

Баруун бүсийн хувьд:

- Юмсыг сонсоод тогтоох чадвар баруун бүсийн хүүхдийн хувьд гүйцэтгэл бусад бүсээс гүйцэтгэл сайтай байна.
- Анхаарлын тогтворжилтыг 3, 4 насанд дэмжих
- Сонорын ой тогтоот Баруун бүсийн хүүхдийн гүйцэтгэл хамгийн бага буюу 4 насанд 25.0 хувь, 5 насанд 41.7 хувь байгаа бол төвийн бүсийн хүүхдийн гүйцэтгэл хамгийн өндөр хувьтай гүйцэтгэсэн байна.

Зүүн бүсийн хувьд:

- Юмсыг ажиглах чадварыг 3-5 насанд дэмжих шаардлагатай.
- Хүүхдүүдийн анхаарлын тогтворжилт 4,5 насанд гүйцэтгэл сайтай, 3 насанд дэмжих
- Сонсоод тогтоох чадварын гүйцэтгэл дунджаас дээш түвшинд байхгүй учир дэмжих

Сэтгэхүй, хэл ярианы чадвар

- Хүүхдийн логиктой сэтгэх чадвар нас нэмэгдэх тусам сайжирсан буюу дунджаас дээш түвшинд гүйцэтгэл нэмэгдсэн байна. Гурван настай хүүхдийн 51.2 хувь, 4 настай хүүхдийн 86.2 хувь, 5 настай хүүхдийн 96.5 хувь нь маш өндөр, өндөр түвшинд даалгавар гүйцэтгэсэн байна.
- Сэтгэхүйн харьцуулан ангилах чадвар нас нэмэгдэх тусам 2.4-13.0 хувь өссөн, 5 насанд 53.5 хувь өссөн байна.
- Сэтгэхүйн нэгтгэн дүгнэх чадвар буюу хүүхдүүд юмсыг харьцуулах, нэгтгэн дүгнэх чадвар нас нэмэгдэх тусам гүйцэтгэл “Өндөр” түвшинд сайжирч байна.

Хэл ярианы чадвар

- Зураг харж санаагаа 5-аас дээш өгүүлбэрээр илэрхийлсэн хүүхдийн хувьд 3 настай хүүхдийн 4.0 хувь нь 7 – оос дээш өгүүлбэрээр, 4 настай хүүхдийн 3.7 хувь нь, 5 настай хүүхдийн 15.5 хувь нь 7-оос дээш өгүүлбэрээр санаагаа илэрхийлсэн байна.
- Зураг харж санаагаа илэрхийлэхдээ хүүхдүүд дунджаар 101.62 сек зарцуулсан байна.
- Судалгаа 1 ба судалгаа 2 хувьд хүүхдийн 5-6 энгийн өгүүлбэрээр санаагаа илэрхийлэх болон 7-оос дээш энгийн өгүүлбэрээр санаагаа илэрхийлэх өгүүлбэрийн тоо нэмэгдсэн байна
- Хүүхдүүд судалгаа 1 -д санаагаа дунджаар 26 үгээр илэрхийлж байсан бол судалгаа 2- т 22 идэвхтэй үг ашиглан санаагаа илэрхийлсэн байна.
- Хүүхдийн нас нэмэгдэх тусам санаагаа илэрхийлж буй үгийн тоо нэмэгддэг байна.
- Хүүхдийн юмс үзэгдлийг логик зүй тогтолын дагуу сэтгэх чадвар хойд бүсэд амьдарч буй хүүхдийн гүйцэтгэл хамгийн бага байгааг дэмжих хэрэгтэй байна.
- Логик сэтгэхүйн даалгавар хойд бүсийн 5 настай хүүхдийн гүйцэтгэл сул байгаа тул дэмжих шаардлагатайг илэрхийлж байна. Зүүн болон баруун бүсийн хүүхдийн гүйцэтгэл нас нэмэгдэх тусам өссөж байна.
- Зураг харж санаагаа 3-4 бүтэн өгүүлбэрээр санаагаа илэрхийлхийг дэмжих шаардлагатай.

Сэтгэхүй, хэл ярианы чадвар бүсээр

Төвийн бүс:

- Судалгаанд хамрагдсан төвийн бүсийн хүүхдийн логиктой сэтгэх чадвар гүйцэтгэл сайтай нас нэмэгдэх тусам өссөн гүйцэтгэлтэй байна.
- Сэтгэхүйн харьцуулан ангилах чадварын гүйцэтгэл нас нэмэгдэх тусам өндөр түвшинд гүйцэтгэх чадвар 4-өөс 5 насанд 11.3 хувь нэмэгдсэн

Хойд бүс:

- Судалгаанд хамрагдсан хойд бүсийн хүүхдийн логиктой сэтгэх чадвар дундажаас дээш түвшинд гүйцэтгэл сул байгааг сургалтаар дэмжих шаардагатай.
- Сэтгэхүйн харьцуулан ангилах чадварын гүйцэтгэл нас нэмэгдэх тусам өндөр түвшинд гүйцэтгэх чадвар нэмэгдсэн

Баруун бүс:

- Хүүхдүүдийн логиктой сэтгэх чадварын гүйцэтгэл нас нэмэгдэх тусам сайжирсан буюу жигд өссөн үзүүлэлттэй байна.

Урд бүс:

- Энэ бүсийн хүүхдийн логик зүй тогтолоор даалгавар гүйцэтгэх чадвар нас нэмэгдэх тусам жигд өссөн гүйцэтгэлтэй байна.

Зүүн бүс:

- Судалгаанд хамрагдсан энэ бүсийн хүүхдийн логиктой сэтгэх чадварын гүйцэтгэл нас нэмэгдэх тусам 16.4 хувиар сайжирсан байна.

1.3 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН НИЙГЭМШИЛ

1.3.1 Сургуулийн өмнөх боловсролын 3-5 насны хүүхдийн өөрийн тухай ойлголт

СӨБ-ын шинэчлэгдсэн сургалтын хөтөлбөрт “XXI зууны иргэний чадамж, үнэт зүйлс дээр суурилсан бөгөөд хүүхдийн **ёс суртахуун, харилцаа, хамтын амьдралын чадварыг** хөгжүүлэх зорилготой бөгөөд нийгэмшлийн чадварыг

- **Бусдыг ойлгох, хайрлах, хамгаалах, хүндлэх** – Хүүхэд өөрөөсөө өөр хүний сэтгэл хөдлөл, хэрэгцээг ойлгож, эерэг харилцаа үүсгэх чадвар
- **Харилцах, хамтран ажиллах** – Хүүхэд тоглоом болон бүлгийн үйл ажиллагаагаар дамжуулан хамтран суралцах, харилцан ойлголцох
- **Сэтгэл хөдлөлөө удирдах** – Уур бухимдал, баяр хөөр зэрэг сэтгэл хөдлөлийг таньж, зохистой илэрхийлэх
- **Зорилготой, тууштай байх** – Хүүхэд өөрийн зорилгыг тодорхойлж, түүний төлөө хичээх, саад бэрхшээлийг даван туулах
- **Аюулгүй, тэгш, хүртээмжтэй амьдралыг бүтээх** – Хүүхдийн эрх, аюулгүй байдал, тэгш оролцоог хүндэтгэх хандлага төлөвшүүлэх

Эдгээр чадваруудыг тоглоомын арга зүй, бүлгийн харилцаа, гэр бүл-цэцэрлэгийн хамтын ажиллагаа, ёс суртахууны хөтөлбөрүүд зэрэг олон талт орчинд хөгжүүлэхээр тусгасан байна.

Хүүхдийн “өөрийн тухай ойлголт”

Энэ нь хүүхэд өөрийгөө **хэн болох, юу мэдэрч байгаа, ямар чадвартай, ямар орчинд амьдарч байгаа** зэргийг танин мэдэх **суурь** болдог гэж үздэг.

Хөгжүүлэх гол чиглэлүүд

- **Биеийн онцлог, нэр, нас, хүйсээ таних** – “Би хүү”, “Намайг Болд гэдэг”, “Би 4 настай” гэх мэтээр өөрийгөө тодорхойлох
- **Сэтгэл хөдлөлөө таних, илэрхийлэх** – “Би баяртай байна”, “Би уурлаж байна” гэх мэтээр сэтгэл хөдлөлөө ойлгож, илэрхийлэх чадвар
- **Чадвар, сонирхлоо таних** – “Би зураг зурах дуртай”, “Би гүйж чадна” гэх мэтээр өөрийн авьяас, сонирхлыг танин мэдэх
- **Бусадтай харьцуулахгүйгээр өөрийгөө хүлээн зөвшөөрөх** – Өөрийн давуу болон сул талыг ойлгож, өөртөө итгэх хандлага төлөвшүүлэх
- **Гэр бүл, орчинтойгоо холбоо тогтоох** – “Би ээжтэйгээ амьдардаг”, “Манай гэрт нохой байдаг” гэх мэтээр орчинтойгоо уялдах гэж СӨБ -ын хөтөлбөрт тусгасан байна.

Шинэчилсэн СӨБ-ын хөтөлбөрт “өөрийн тухай ойлголт”-ыг дараах **арга зүйгээр хөгжүүлэхийг** тусгасан:

- Тоглоомын орчинд өөрийгөө илэрхийлэх боломж олгох
- Сэтгэл хөдлөлийн тухай яриа, дүрслэл, зураг ашиглах
- Бие даасан байдлыг дэмжих үйл ажиллагаа (жишээ нь: хувцсаа өмсөх, сонголт хийх)
- Гэр бүл, багш, найз нөхдийн дэмжлэгтэй харилцааны тухай ойлголттой болго гэж тусгасан байна.

Хүүхдийн өөрийн тухай ойлголтыг нэрээ мэддэг эсэх, хэдэн настай, хүйсээ зөв хэлж буй байдал, аав, ээжийнхээ нэрийг мэддэг эсэх болон гэртээ хэдүүлээ амьдардаг, цэцэрлэгийн ямар бүлэгт явдагаа нэрлэж мэдэж байгааг асуулгаар хариултын хувилбаруудтай авч үзлээ.

д/д	Сэтгэлийн хөдөлгөөн		Харилцааны чадвар
1.	Өөрийн мэдрэх	сэтгэлийн хөдөлгөөнийг	Үе тэнгийнхэнтэйгээ харилцах, хамтарч тоглох
2.	Бусдын мэдрэх	сэтгэлийн хөдөлгөөнийг	Бусдаас дэмжлэг авах чадвар

Бидний даалгаврын найдвартай чанар 0.777 (Cronbach's Alpha) гарсан тул нийгэмшлийн чадваруудыг сорил даалгаврууд тодорхойлж чадсан гэж үзлээ.

Өөрийн тухай ойлголт

Сургуулийн өмнөх наснаас эхлэн хүүхэд өөрийнхөө талаар маш их зүйлийг мэддэг, өөрийн мэдрэмж, зан аашаа хэрхэн удирдахаа мэддэг болох ба дур зоргоороо зан авир ч гаргаж эхэлдэг. Хоёр нас таван сартайгаас эхлэн танин мэдэхүйн хөгжилтэй зэрэгцэн хүүхдийн бэлгийн чиг баримжаа явагдаж, 3 настайдаа ихэнх хүүхдүүд насаа төдийгүй хүйсээ нэрлэж чаддаг болсон байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдийн өөрийн болон аав, ээжийн нэр, өөрийн нас, хүйсээ нэрлэх, гэртээ хэдүүлээ амьдардаг, ямар бүлэгт сурдаг зэргээ илэрхийлж байгаа байдлаар тэдний өөрийгөө илэрхийлэх чадварыг судлав.

		Өөрийн тухай ойлголтууд						
		Нэрээ мэддэг	Насаа мэддэг	Хүйсээ мэддэг	Аавын нэр	Ээжийн нэр	Ам бүлийн тоо	Бүлэгээ мэддэг
Дундаж		3.98	3.90	4.00	3.75	3.77	3.58	2.54
Ст. алдаа		0.02	0.05	0.00	0.08	0.06	0.11	0.20
Итгэх муж	Доод	3.94	3.79	4.00	3.59	3.65	3.37	2.14
	Дээд	4.02	4.00	4.00	3.91	3.89	3.80	2.95
Median		4.00	4.00	4.00	4.00	4.00	4.00	2.00
Variance		0.02	0.14	0.00	0.32	0.18	0.55	1.96
Ст.хазайлт		0.14	0.37	0.00	0.56	0.42	0.74	1.40
Бага утга		3.0	2.0	4.0	1.0	3.0	2.0	1.0
Maximum		4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0	4.0
Range		1.0	2.0	0.0	3.0	1.0	2.0	3.0

Хүүхдүүдэд өөрийн тухай ойлголт 3 наснаас бий болдог байна. Харин өөрийн суралцаж буй бүлгийнхээ нэрийг би цэцэрлэгтээ сурдаг, би ангидаа сурдаг гэх мэтээр хариулдаг байна.

Хүснэгт 37. Өөрийн тухай ойлголт - Өөрийн нэрийг мэддэг байдал, насаар (3-5 нас, хувь)

Нэр, нас, хүйсээ таних чадвар	3 нас	4 нас	5 нас	Нийт
Нэрээ хэлээгүй	1.2	2.4	0	1.2
Гэр бүлийнхэн нь нэрлэдэг нэрээ хэлсэн	1.2	0	0	0.4
Нэрээ хагасалж хэлсэн	8.3	2.4	2.4	4.4
Нэрээ бүтэн хэлсэн	89.3	95.2	97.6	94.0

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 3 настай хүүхдийн 89.3 хувь өөрийгөө бүтэн нэрээрээ нэрлэж танилцуулдаг, нас нэмэгдэх тусам чадвар сайжирдаг байна. Судалгаанд хамрагдсан хүүхдийн байршилаар авч үзэхэд орон нутагт амьдарч буй хүүхдийн 95.8 хувь нь өөрийн нэрээ бүтэн хэлж танилцуулсан байна.

Хүснэгт 38. Өөрийн насаа мэддэг эсэх, хувиар (3-5 нас)

Нэр, нас, хүйсээ таних чадвар	3 нас	4 нас	5 нас	Нийт
Насаа хэлээгүй	2.4	2.4	0.0	1.6

Насаа буруу хэлсэн	9.5	10.7	1.2	7.1
Насаа хуруугаараа зөв харуулсан	22.6	17.9	2.4	14.3
Насаа зөв хэлсэн	65.5	69.0	96.4	77.0

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 3 настай хүүхдийн 65.5 хувь нь өөрийн насаа мэддэг, 5 настай хүүхдийн 96.4 хувь насаа зөв танилцуулж байгаа ч 3 настай хүүхдийн 22.6 хувь, 5 настай хүүхдийн 2.4 хувь нь насаа хуруугаараа харуулсан байна.

Хүснэгт 39. Өөрийн хүйсээ мэддэг эсэх, насаар (3-5 нас)

<i>Нэр, нас, хүйсээ таних чадвар</i>	<i>3 нас</i>	<i>4 нас</i>	<i>5 нас</i>	<i>Нийт</i>
Хүйсээ хэлээгүй	8.3	0.0	1.2	3.2
Хүйсээ буруу хэлсэн	13.1	11.9	0.0	8.3
Хүйсээ зөв хэлсэн	78.6	88.1	98.8	87.7

Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдийн 78.6 хувь нь хүйсээ зөв танилцуулсан, 5 настай хүүхдийн 98.8 хувь нь хүйсийн тухай ойлголттой болсон байна. Харин нийт хүүхдийн 3.2 хувь нь хүйсээ хэлээгүй, 8.3 хувь нь хүйсээ буруу хэлсэн байна.

Хүснэгт 40. Аавынхаа нэрийг мэддэг эсэх, хувиар (3-5 нас)

<i>Нэр, нас, хүйсээ таних чадвар</i>	<i>3 нас</i>	<i>4 нас</i>	<i>5 нас</i>	<i>Нийт</i>
Аавынхаа нэрийг хэлээгүй	16.7	8.3	2.4	9.1
Аавынхаа нэрийг буруу хэлсэн	2.4	2.4	1.2	2
Аавынхаа нэрийг хагасалж хэлсэн	23.8	22.6	9.5	18.7
Аавынхаа нэрийг бүтэн хэлсэн	57.1	66.7	86.9	70.2

Аавынхаа нэрийг 3 настай хүүхдийн 57.1 хувь, 4 настай хүүхдийн 66.7 хувь нь, 5 настай хүүхдийн 86.9 хувь нь өөрийнхөө аавын нэрийг хэлж танилцуулсан байна.

Хүснэгт 41. Ээжийнхээ нэрийг мэддэг эсэх, хувиар (3-5 нас)

	<i>3 нас</i>	<i>4 нас</i>	<i>5 нас</i>	<i>Нийт</i>
Ээжийнхээ нэрийг хэлээгүй	13.1	8.3	3.6	8.3
Ээжийнхээ нэрийг буруу хэлсэн	7.1	2.4	1.2	3.6
Ээжийнхээ нэрийг хагасалж хэлсэн	32.1	27.4	11.9	23.8
Ээжийнхээ нэрийг бүтэн хэлсэн	47.6	61.9	83.3	64.3

Ээжийнхээ нэрийг 3 настай хүүхдийн 47.6 хувь, 4 настай хүүхдийн 61.9 хувь нь, 5 настай хүүхдийн 83.3 хувь нь танилцуулсан байна.

Хүснэгт 42. Ам бүлийн тоог хэлсэн байдал, хувиар (3-5 нас)

	<i>3 нас</i>	<i>4 нас</i>	<i>5 нас</i>	<i>Нийт</i>
--	--------------	--------------	--------------	-------------

Хэлээгүй/ мэдэхгүй	8.3	3.6	1.2	4.4
Би аав, ээж, дүү, ахтай гэх мэтээр хэлсэн	63.1	61.9	59.5	61.5
Хэдэн ам бүлтэйгээ зөв хэлсэн	28.6	41.7	66.7	45.6


Гурван настай хүүхдийн 71.4 хувь хариулж мэдэхгүй байсан бол би агаа, аав, ээж, дүү ахтайгаа амьдардаг гэж точсон байдлаар 63.1 хувь нь хариулжээ. 3 настай хүүхдийн 28.6 хувь, 4 настай хүүхдийн 41.7 хувь, 5 настай хүүхдийн 66.7 хувь нь гэр бүлийн гишүүдийн тоог зөв хэлжээ. Гурав дөрвөн настай хүүхдүүд ам бүлийнхээ тоог хэлхээс илүү аав ээж, ах, дүүтэйгээ амьдардаг гэж тоочиж нэрлэдэг байна.

Хүснэгт 43. Суралцдаг бүлэг нэрлэсэн эсэх, хувиар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хэлээгүй/ мэдэхгүй	36.9	22.6	15.5	25
Би ангидаа/ цэцэрлэгт явдаг	22.6	23.8	7.1	17.9
Бүлгээ буруу хэлсэн	13.1	26.2	10.7	16.7
Бүлгээ зөв хэлсэн	27.4	27.4	66.7	40.5


Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 5 настай хүүхдийн 66.7 хувь нь, 4 настай хүүхдийн 27.4 хувь нь, 3 настай хүүхдийн 27.4 хувь нь суралцаж буй бүлгийн нэрээ хэлж танилцуулсан байна. Хүүхдүүд 3 насандаа өөрийнхөө хүйс, нэр, ээж аавынхаа нэрийг болон өөрийн суралцаж буй бүлэг, гэр бүлийн гишүүдийн тухай ойлголтой болсон байдаг байна.

Зураг 59. Өөрийн тухай ойлголт 3 настай хүүхдүүд бүсээр




Хүүхдүүд 3 насандаа өөрийн насаа зөв хэлэх, гэр бүлийн ам бүлийн тоогоо хэлэх, суралцаж буй бүлгийнхээ нэрийг мэдэх хэлэх нь бүс тус бүрд ялгаатай хүйс, нэрээ мэдэх чадвараас сул байгаа тул сургалтаар дэмжих шаардлагатай байна.

Зураг 60. Өөрийн тухай ойлголт 4 настай хүүхдүүд бүсээр



Хүүхдүүд 4 насандаа аавынхаа нэр, гэртээ хэдүүлээ амьдарч буй ам бүлийн тоогоо хэлэх, суралцаж буй бүлгийнхээ нэрийг мэдэх хэлэх нь бүс тус бүрд сул байгаа тул сургалтаар дэмжих шаардлагатай байна.

Зураг 61. Өөрийн тухай ойлголт 5 настай хүүхдүүд бүсээр



Хүүхдийн нас нэмэгдэх тусам нэр, нас, хүйсээ таних мэдэх чадвар сайжирдаг байна. Өмнөх наснаас 5 настай хүүхдийн гүйцэтгэл бүс бүрд сайжирсан байна.

1.3.2 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН 3-5 НАСНЫ ХҮҮХДИЙН СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨН, ХАРИЛЦАА /ХЭМ ХЭМЖЭЭ/

Сэтгэлийн хөдөлгөөнөө таних, илэрхийлэх

Хүүхдийн өөрийн дуртай зүйлийг хэлэх, ямар үед уурладаг, уйтгар гунигтай байдаг, ямар үед гоё, баяртай байдаг талаар өөрийн сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх чадварыг авч үзлээ.

Хүснэгт 44. Сэтгэлийн хөдөлгөөнөө мэдэх, хувиар (3-5 нас)

Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, таних чадвар	3 нас	4 нас	5 нас	Нийт
Сэтгэл хөдлөл ялгаж ойлгохгүй, хэлээгүй	16.7	7.1	2.4	8.7
Хариулт тодорхой биш	26.2	8.3	4.8	13.1
Өөрт тохиолдсон үйл явдал дурдаж байгаа бол	9.5	4.8	2.4	5.6
Тодорхой нөхцөл нэрлэж байгаа бол	47.6	79.8	90.5	72.6


Судалгаанд хамрагдсан хүүхдийн 72.6 хувь нь эерэг сэтгэлийн хөдөлгөөнөө ямар үед хэрхэн илэрч байсан тухайгаа ярьж байсан бол 3 настай хүүхдийн 16.7 хувь нь хэлээгүй, 26.2 хувь нь юу гэж хариулж байгаа нь тодорхойгүй байна. Хүүхдийн нас нэмэгдэх тусам ямар сэтгэл хөдлөл ямар үед үүсдэг тухай мэддэг, ялгаж тайлбарладаг болдог байна.

Хүснэгт 45. Сөрөг сэтгэлийн хөдөлгөөнөө мэдэх, хувиар (3-5 нас)

Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, таних чадвар	3 нас	4 нас	5 нас	Нийт
Сөрөг сэтгэл хөдлөл ялгаж ойлгохгүй, хэлээгүй	32.1	20.2	4.8	19
Сөрөг сэтгэл хөдлөлийн талаарх хариулт тодорхой биш	22.6	8.3	6	12.3
Өөрт тохиолдсон үйл явдал дурсан тайлбарласан	8.3	6	4.8	6.3
Сөрөг сэтгэл хөдлөл үүссэн тодорхой нөхцөл нэрлэж байгаа бол	36.9	65.5	84.5	62.3


Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдийн 36.9 хувь, 4-настай хүүхдийн 65.5 хувь, 5 настай хүүхдийн 84.5 хувь нь ямар үед тааламжгүй уйтгартай, гунигтай, ууртай болдог талаар тодорхой жишээ авч хариулсан байна. Харин нийт хүүхдийн 31.3 хувь яагаад ууртай, гунигтай болдог талаар тодорхой хариулт өгч чадаагүй байна. Хүүхдийн өөрийн сөрөг сэтгэл хөдлөлийг таньж мэдэх чадвар нас нэмэгдэх тусам сайжирдаг байна.

Зураг 62. Өөрийн сэтгэл хөдлөл илэрхийлэх байдал (3 нас, бүсээр)




Хүүхэд өөрийн сэтгэл хөдлөлийг илэрхийлж таньж байгаа байдлыг авч үзэхэд 3 настай хойд бүсийн хүүхдүүд эерэг, сөрөг сэтгэл хөдлөлөө илэрхийлэх байдал маш сул байна. Урд болон төвийн бүсийн хүүхдүүд сөрөг сэтгэл хөдлөлийг илэрхийлэх байдал сул байна.

Зураг 63 Өөрийн сэтгэл хөдлөл илэрхийлэх байдал (4 нас, бүсээр)



Хүүхдүүд 4 нас хүрээд эерэг болон сөрөг сэтгэлийн хөдлөлийн илрэлийг таних чадвар өмнөх наснаас гүйцэтгэл сайжирдаг байна.

Зураг 64. Өөрийн сэтгэл хөдлөл илэрхийлэх байдал (5 нас, бүсээр)



Хойд болон урд бүсийн 5 настай хүүхдүүд сөрөг сэтгэл хөдлөлийг таних чадвар бусад бүсээс гүйцэтгэл бага зэрэг доогуур байна.


Бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг таних чадвар

Хүүхдийн биеийн хөдөлгөөн, нүүрний хувирлаар ямар сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлж байгааг тодруулах сорил гүйцэтгүүлсэн.

Баяр хөөртэй, гунигтай, ууртай гэх мэт эерэг, сөрөг сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлсэн зургаас гунигтай байгаа хүүхдийг олох даалгаврыг 3 настай хүүхдийн 88.1 хувь, 4-5 настай хүүхдүүд 100 хувь гүйцэтгэсэн байна. Хүүхдүүд бие биенийхээ бие биенийхээ нүүрний хувирал, биеийн хөдөлгөөнийг харж ямар сэтгэлийн хөдөлгөөнтэй байгааг ялгаж чаддаг байна.

Сэтгэлийн хөдөлгөөний янз бүрийн байдалтай хүүхдүүдээс гайхаж, баярлаж, уурлаж, гомдсон байгаа байдалтай хүүхдийн зургийг 3 настай хүүхдийн 59.5 хувь нь, 4-5 настай хүүхдүүд 100 хувь зөв таньж олсон ба хүүхдүүд бие биенийхээ нүүрний хувирал, биеийн хөдөлгөөнөөс харж ямар сэтгэлийн хөдөлгөөнтэй байгааг ялгаж таних нь ууртай байгаа баярлаж байгаа нүүр царайны илрэлийг таних боломжтой болдог байна.

Зураг 65. Бусдын сэтгэл хөдлөлийг таних байдал (3 нас, бүсээр)



Бусдын сэтгэл хөдлөлийг таних байдал баруун бүсийн 3 настай хүүхдийн хувьд бусад бүсийн хүүхдийн гүйцэтгэлээс сул байна.

Харилцааны чадвар

Хүүхдүүд цэцэрлэгтээ нийгмийн харилцаанд орж өөрийгөө болон бусдыг таньж, сэтгэл хөдлөлөө барьж зохицуулж эхэлдэг. Хүүхэд насанд хүрэгчидтэй харилцах харилцаа өөрчлөгдөж, аажмаар насанд хүрэгчдийн зааврыг бие даан биелүүлж эхэлдэг ба хүүхэд үе тэнгийнхэнтэйгээ тодорхой харилцаанд орж эхэлдэг (нийгмийн орчин өөрчлөгдөж цэцэрлэгт хамрагдах гэх мэт). Энэ насанд хүүхдүүдэд шинэ хэрэгцээ буюу үе тэнгийнхэнтэйгээ харилцах хэрэгцээ гарч, үе тэнгийнхэнтэйгээ харьцах харьцаа эрс өөрчлөгддөг. Хүүхдүүд бие биетэйгээ хамтдаа тоглох, санал бодол, сэтгэгдлээ хуваалцах боломж болно.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн нийгэмшлийн хөгжилд тоглоом чухал үүрэгтэй. Хүүхдийн хоорондын жинхэнэ харилцаа бол хамтран тоглох үед үүснэ. Тоглох явцад үүсгэсэн бодит харилцаа нь хүүхдийн хувийн хөгжлийн шинж чанар, үе тэнгийнхний хоорондын харилцааны шинж чанараар тодорхойлогдоно. А.П.Усова, С.Н.Карпова, Л.Г.Лысюк нарын эрдэмтэд бодит харилцаа нь хүүхдийн харилцааны болон нийгмийн чадамжийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж тэмдэглэсэн байна. Тоглоомын ид өрнөл хэсэгт харилцааны хэм хэмжээ дэх чиг баримжаа бодитоор бие биенээ хүлээн зөвшөөрч хамтран тоглох, эсвэл тоглохоо болих гэх зэргээр илэрдэг байна. Тоглох үед хүүхдийн танин мэдэхүйн чадварууд, мэдрэмж, анхаарал, ой тогтоолтын үндсэн сэргээн санах, таних процессууд, төсөөлөл, сэтгэхүй, нийгэмшлийн үзүүлэлтүүд болох харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, мэдрэмж, хүсэл эрмэлзлийг бий болгодог. Төсөөлөл, дүрслэх, дүрслэх сэтгэлгээ түүнийг хөгжүүлэх үндэс нь тоглоом юм. Тоглоомын үйл ажиллагаа нь төсөөллийн үйл явцыг бий болгодог. Ж.Пиажегийн үзэж байгаагаар сургуулийн өмнөх насны хүүхэд тоглоом, бодит байдал гэсэн хоёр ертөнцөд нэгэн зэрэг амьдардаг.

Харилцааны чадварыг хүүхдүүд найзтай эсэх, найзуудтайгаа тоглодог эсэх, тоглоомоо хуваалцдаг талаар авч үзлээ.

	Харилцааны чадвар			Бусдаас дэмжлэг авах чадвар		Дүрэм, журам баримт чадвар		
	Найзтай эсэх	Хамтран тоглодог эсэх	Тоглоомоо хуваалцаг эсэх	Ойр байгаа хүнээс тусламж авах	Бусдаас тусламж авах	Дүрэм баримтлах	Олон нийтийн газар дүрэм баримтлах	
Үзүүлэлтүүд								
Дундаж	2.94	2.94	3.59	3.75	3.73	3.91	3.66	
Ст.хазайлт	0.02	0.03	0.06	0.05	0.05	0.04	0.07	
Итгэх муж	Доод	2.89	2.89	3.48	3.64	3.62	3.84	3.54
	Дээд	2.98	3.00	3.70	3.86	3.83	3.98	3.79

Ст.хазайлт	0.27	0.33	0.66	0.66	0.62	0.43	0.78
Бага утга	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0	1.0
Их утга	3.0	3.0	4.0	4.0	4.0	4.0	4.0

Хүүхдүүдийн гүйцэтгэлийн дундаж үзүүлэлт дундажаас өндөр түвшинд байна.

Хүснэгт 46. Найзтай эсэх талаарх асуултын хариулт

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Найзтай эсэхээ хэлээгүй	3.6	0	0	1.2
Найзгүй	9.5	4.8	1.2	5.2
Найзуудынхаа нэрийг хэлсэн	86.9	95.2	98.8	93.7

СӨБ -д суралцаж буй 3 насны хүүхдийн 86.9 хувь нь, 4-5 настай хүүхдийн 95.2- 98.8 хувь нь найзтай байна.

Хүснэгт 47. Найзуудтайгаа тоголдог, хэрхэн тоглодог талаар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хэрхэн тоголдог талаар хэлээгүй	6.0	0.0	2.4	2.8
Хамтран найзуудтайгаа тоглодоггүй	2.4	1.2	1.2	1.6
Найзуудтайгаа хэрхэн тоглодог хэлсэн	91.7	98.8	96.4	95.6


Хүүхдээс найзуудтайгаа хэрхэн тоголдог талаар асуухад 3 настай хүүхдийн 2.4 хувь нь хамтран тоглодоггүй, 4,5 настай хүүхдийн 1.2 хувь нь хамтран тоглодоггүй ганцаараа тоглодог гэсэн бол нийт хүүхдийн 95.6 хувь нь найзуудтайгаа хэрхэн тоглодог тухайгаа тайлбарлан ярьсан байна.

Хүснэгт 48. Хүүхэд тоглоомоо хуваалцах байдал (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хариулаагүй/мэдэхгүй	8.3	1.2	2.4	4
Тоглоомоор ганцаараа тоглоно	3.6	8.3	0	4
Тоглоом өгнө	40.5	26.2	34.5	33.7
Хамт тоглоно	47.6	64.3	63.1	58.3


Хүүхдүүд тоглоомоо найзуудтайгаа хувааж тоглох талаарх ойлголт 3 наснаас бий болдог байна. Гурван настай хүүхдийн 13.3 хувь нь ганцаараа тоглоомоороо тоглох дуртай гэсэн бол найздаа тоглоомоо өгнө, хамт тоглоно гэж 47.6 хувь нь хариулсан байна.

Зураг 66. Үе тэнгийнхэнтэйгээ хамтран тоглох (3 нас, бүсээр)




Төвийн бүсийн хүүхдүүд найзуудтайгаа хамтран тоглоно гэсэн хариулт хамгийн өндөр хувьтай байгаа бол баруун болон зүүн бүсийн хүүхдийн хамтран тоглох гэсэн хариулт хамгийн бага байна.

Зураг 67. Үе тэнгийнхэнтэйгээ хамтран тоглох (4 нас, бүсээр)



Судалгаанд хамрагдсан 4 настай хүүхдийн найзууддаа тоглоомоо өгч хуваалцана гэсэн ойлголт бага байна.

Зураг 68. Үе тэнгийнхэнтэйгээ хамтран тоглох (5 нас, бүсээр)



Судалгаанд хамрагдсан 5 настай хүүхдийн найзууддаа тоглоомоо өгч хуваалцана гэсэн хариулт хамгийн бага байна.

Бусдаас дэмжлэг авах чадвар

Хүснэгт 49. Аюул тохиолдсон үед бусдаас тусламж, дэмжлэг авах чадвар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
--	-------	-------	-------	------

Хариулаагүй	7.1	3.6	1.2	4.0
Уйлна гэнэ	11.9	1.2	0.0	4.4
Хажууд байгаа хүнээс тусламж хүснэ	8.3	10.7	14.3	11.1
Ээж, аав, эмээ, өвөө, эмч дээр очно	72.6	84.5	84.5	80.6


Хүүхдүүд тоглох явцдаа унах тохиолдол цөөнгүй байдаг. Ийм үед хэрхэх тухай тодруулахад 3 настай хүүхдийн 7.1 хувь, 4-5 настай хүүхдийн 4.8 хувь нь хариулж чадаагүй бол хажууд байгаа хэн нэгнээс тусламж авна гэж 3 настай хүүхдийн 8.3 хувь, 4-5 настай хүүхдийн 25.0 хувь нь хариулсан бол зөвхөн ойрын хүмүүсээс тусламж хүснэ гэж 3 настай хүүхдийн 72.6 хувь, 4-5 настай хүүхдийн 84.5 хувь нь хариулсан байгаа нь яаралтай аюултай зүйл тохиолдсон үед хамгийн ойр байгаа хэн нэгнээс тусламж хүсэх тухай ойлголттой болгох хэрэгтэй байна.

Хүснэгт 50. Өөрт хэрэгтэй зүйл авах үед бусдаас тусламж, дэмжлэг авах чадвар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хариулаагүй/мэдэхгүй	10.7	4.8	2.4	6.0
Хүнээс тусламж авахгүй/ ном авахгүй	2.4	3.6	1.2	2.4
Аав, ээж, ах, эгчээсээ тусламж авна	36.9	38.1	16.7	30.6
Худалдагч/ хажууд байгаа хүнээс тусламж авна	50.0	53.6	79.8	61.1


Хүүхдүүд өөрт хэрэгтэй зүйлийг авах үедээ өөрт хамгийн ойр хажууд байгаа хүнээсээ тусламж дэмжлэг авна гэж 3 настай хүүхдийн 50.0 хувь, 5 настай хүүхдийн 79.8 хувь хариулсан байна. Хэрэгцээтэй зүйлээ авах гэж аав ээж гэх мэт гэр бүлийн гишүүдээс л тусламж авна гэж 3 настай хүүхдийн 36.9 хувь, 5 настай хүүхдийн 16.7 хувь нь хариулсан байна. Хэрхэн яах тухай хариулж чадаагүй 3 настай хүүхдийн 10.7 хувь байна.

Зураг 69. Бусдаас дэмжлэг авах чадвар (3 нас, бүсээр)




Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдүүд зөвхөн ойр дотны таньдаг хүнээсээ тусламж авна гэж хариулсан байна.

Зураг 70. Бусдаас дэмжлэг авах чадвар (4 нас, бүсээр)



Судалгаанд хамрагдсан 4 настай хүүхдүүд зөвхөн ойр дотны таньдаг хүнээсээ тусламж авна гэж хариулсан байна. төвийн бүсийн хүүхдийн 63.9 хувь нь, урд бүсийн хүүхдийн 66.7 хувь нь хажууд байгаа хүнээс тусламж гуйна гэж хариулсан байна.

Зураг 71. Бусдаас дэмжлэг авах чадвар (5 нас, бүсээр)



Судалгаанд хамрагдсан 5 настай хүүхдүүд өмнөх насны хүүхдийг бодвол ойр дотны болон яаралтай үед хажууд ойрон байгаа хүнээс тусламж гуйна гэж хариулсан байна.

Дүрэм, журам баримтлах чадвар

Хүснэгт 51. Дүрэм, журам баримтлах чадвар (3-5 нас)

	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хариулаагүй/мэдэхгүй	2.4	0.0	0.0	0.8
Зөв хаяж болно	1.2	0.0	1.2	0.8
Хогийн сав ойрхон биш бол хаяж болно.	2.4	1.2	2.4	2.0
Болохгүй	94.0	98.8	96.4	96.4

Хогийн сав ойрхон биш бол хогоо хаяж болно гэж нийт хүүхдийн 0.8 хувь нь хариулсан бол нийт хүүхдийн 96.4 хувь нь заавал хогийн саванд хогоо хаях ёстой гэсэн ойлголттой болсон байна. Хүүхдүүд хог хаях нь ямар хортой талаар учир шалтгааныг тайлбарласан хариултуудыг эрэмблэн авч үзвэл орчноо бохирдуулна, гэрээ муухай болгоно, байгаль, дэлхийгээ муухай болгоно гэсэн хариултууд давамгайл байна.


Хүснэгт 52. Олон нийтийн газар дүрэм журам баримтлах чадвар (3-5 нас)

Хариулт	3 нас	4 нас	5 нас	Нийт
Хариулаагүй/мэдэхгүй	3.6	1.2	0	1.6
Зөв	11.9	8.3	3.6	7.9
Уйлж байгаа нь буруу/муухай байна	1.2	0	1.2	0.8
Буруу	83.3	90.5	95.2	89.7

Олон нийтийн газар хүүхэд өөрийн авах гэсэн зүйлийг уйлж байж авах явдал байдаг. Олон нийтийн газар уйлах нь зөв гэж 3 настай хүүхдийн 11.9 хувь нь, 4 настай хүүхдийн 8.3 хувь, 5 настай хүүхдийн 3.6 хувь нь хариулсан байна. Харин ингэж уйлж өөрийн хүссэн зүйлийг авах нь буруу гэж 3 настай хүүхдийн 83.3 хувь, 4 настай хүүхдийн 90.5 хувь, 5 настай хүүхдийн 95.2 хувь нь хариулсан байгаагаас үзэхэд өөрийн санал сэтгэл хөдлөлийг хүүхдүүд хаана яаж гаргах талаар тодорхой мэдлэгтэй болсон байдаг байна.


Хүүхдүүдийн дүрэм журам баримтлах чадварыг авч үзэхэд зөв буруу гэж хариулсан хариултынхаа шалтгааныг 3 насны хүүхдийн 36.9 хувь тайлбарлаагүй бол 23.8 хувь дутуу тайлбарласан, 77.4 хувь нь яагаад тэгэх ёстой шалтгааныг тайлбарласан байна.

Зураг 72. Дүрэм журам баримтлах чадвар (3 нас, бүсээр)




Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдүүд хогоо заавал хогийн саванд хогоо хаях тухай ойлголттой болсон байдаг ба яагаад хогийн саванд хийх ёстой шалтгааныг тайлбарласан байна.

Зураг 73. Дүрэм журам баримтлах чадвар (4 нас, бүсээр)



Судалгаанд хамрагдсан 4 настай хүүхдүүд хогоо заавал хогийн саванд хогоо хаях тухай ойлголттой болсон байдаг ба яагаад хогийн саванд хийх ёстой шалтгааныг урд бүсэд амьдардаг хүүхдүүд бага хувьтай тайлбарласан байна.

Зураг 74. Дүрэм журам баримтлах чадвар (5 нас, бүсээр)



Судалгаанд хамрагдсан 5 настай хүүхдүүд хогоо заавал хогийн саванд хогоо хаях тухай ойлголттой болсон байдаг ба яагаад хогийн саванд хийх ёстой шалтгааныг урд бүсэд амьдардаг хүүхдүүд бага хувьтай тайлбарласан байна.

Нийгэмшлийн үзүүлэлтүүдийн хамаарал

Хүснэгт 53. Өөрийн тухай ойлголтуудын хамаарал

		Өөрийн тухай ойлголт				Сэтгэл хөдлөл	
		Аавынх нь нэрийг мэддэг эсэх	Ээжийнхээ нэрийг мэддэг эсэх	Ам бүлийнхээ тоог мэддэг эсэх	Цэцэрлэгийн сурдаг ангиа нэрлэж мэддэг эсэх	Эерэг сэтгэл хөдлөлийг таньдаг эсэх	сөрөг сэтгэлийн хөдөлгөөнийг таньдаг эсэх
Хүйсийг мэддэг эсэх	Pearson Cor	.350**	.342**	.270**	.162**	.334**	.393**
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.010	0.000	0.000
Аавынхаа нэрийг мэддэг эсэх	Pearson Correlation	1	.602**	.431**	.171**	.244**	.373**
	Sig. (2-tailed)		0.000	0.000	0.006	0.000	0.000
Ээжийнхээ нэрийг мэддэг эсэх	Pearson Correlation		1	.430**	.198**	.343**	.355**
	Sig. (2-tailed)			0.000	0.002	0.000	0.000
Ам бүлийнхээ тоог мэддэг эсэх	Pearson Correlation			1	.396**	.309**	.298**
	Sig. (2-tailed)				0.000	0.000	0.000
Сурдаг бүлгээ мэддэг эсэх	Pearson Correlation				1	.306**	.334**
	Sig. (2-tailed)					0.000	0.000
Эерэг сэтгэл хөдлөлийг таньдаг эсэх	Pearson Correlation					1	.625**
	Sig. (2-tailed)						0.000

Хүүхэд өөрийн тухай ойлголттой болох тусам эерэг сэтгэлийн хөдөлгөөн, сурдаг бүлгийн тухай ойлголттой болдог байна.

Хүснэгт 54. Харилцаа ба дүрэм журам баримтлах чадваруудын хамаарал

		Харилцаа			Дүрэм журам баримтлах			
		Найзтай эсэх	Хамтран тоглодог эсэх	Аюултай үед тусламж авдаг эсэх	Бусдаас тусламж авдаг эсэх	Хогоо хогийн саванд хийдэг эсэх	Олон нийтийн газар дүрэм баримтлах	Дүрэм баримтлах
Өөрийнхөө хүйсийг мэддэг эсэх	Pearson Correlation		.309**		.230**			.325**
	Sig. (2-tailed)		0.000		0.000			0.000
Аавынх нь нэрийг мэддэг эсэх	Pearson Correlation	.186**	.256**					.273**

	Sig. (2-tailed)	0.003	0.000					0.000
Ээжийнхээ нэрийг мэддэг эсэх	Pearson Correlation		.283**			.185**	.167**	.251**
	Sig. (2-tailed)		0.000			0.003	0.008	0.000
Ам бүлийнхээ тоог мэддэг эсэх	Pearson Correlation	.284**	.279**	.200**	.173**	.227**	.256**	.370**
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.001	0.006	0.000	0.000	0.000
Цэцэрлэгийн сурдаг ангиа нэрлэж мэддэг эсэх	Pearson Correlation		.168**	.194**	.245**		.170**	.306**
	Sig. (2-tailed)		0.008	0.002	0.000		0.007	0.000
Эерэг сэтгэл хөдлөлийг таньдаг эсэх	Pearson Correlation	.219**	.207**	.386**	.336**	.275**	.263**	.348**
	Sig. (2-tailed)	0.000	0.001	0.000	0.000	0.000	0.000	0.000
сөрөг сэтгэлийн хөдөлгөөнийг таньдаг эсэх	Pearson Correlation	.169**	.220**	.346**	.385**	.205**	.207**	.397**
	Sig. (2-tailed)	0.007	0.000	0.000	0.000	0.001	0.001	0.000
Найзуудтайгаа хамт тоглодог эсэх	Pearson Correlation	1	.353**	.329**	.343**	.491**	.212**	.220**
	Sig. (2-tailed)		0.000	0.000	0.000	0.000	0.001	0.000
Тоглоомоо хуваалцан хамтран тоглодог эсэх	Pearson Correlation		1	.166**	.191**	.213**	.317**	
	Sig. (2-tailed)			0.008	0.002	0.001	0.000	
Унаж бэртэх үед бусдаас тусламж авдаг эсэх	Pearson Correlation			1	.530**	.269**	.380**	.275**
	Sig. (2-tailed)				0.000	0.000	0.000	0.000
Гар хүрэхгүй зүйл авах үед бусдаас тусламж авдаг эсэх	Pearson Correlation				1	.313**	.334**	.303**
	Sig. (2-tailed)					0.000	0.000	0.000
Хогоо хогийн саванд хийдэг эсэх	Pearson Correlation					1	.367**	.221**

Харилцаа ба дүрэм журам баримтлах чадвар хүүхдэд бий болох тусам найзуудтайгаа тоглох, тоглоомоо хуваалцах, бусдаас тусламж авах чадварууд хоорондоо хамааралтайгаар бий болдог байна.

Дүгнэлт:

Нийгэмшлийн чадваруудыг өөртөө хандах хандлага, харилцаа, сэтгэлийн хөдөлгөөн, дүрэм журам баримтлах чадваруудаар авч үзлээ. СӨБ -ын шинэчилсэн хөтөлбөрийн нийгэм-сэтгэл хөдлөл хөтөлбөрийн зорилго нь хүүхэд сэтгэл хөдлөл, мэдрэмж, харилцаа хүмүүнлэг байдлын талаарх ойлголт мэдлэгтэй бусадтай эерэгээр харилцах, хамтрах, сэтгэл хөдлөлөө удирдан зохицуулах чадвартай, өөрт болон бусдад энэрэнгүй, эрх тэгш, хүндэтгэлтэй болж төлөвшинө гэж тодорхойлжээ.

2019 оны сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлэх зөвлөмжид хүүхдэд эзэмшүүлэх 12 чадварыг тусгасан байна. 1.Өөрийгөө мэдрэх, илэрхийлэх 2.Өөртөө үйлчлэх, оролцоотой байх 3.Сэтгэлийн хөдөлгөөнөө зохистой илэрхийлэх 4. Асуудлыг өөрийн хэмжээнд шийдвэрлэх 5.Бусдыг мэдэрч ойлгох 6.Насанд хүрэгчидтэй харилцах 7.Үеийн хүүхдүүдтэй харилцах 8.Бусад хүүхэд (өөрөөсөө насаар ах, дүү)-тэй харилцах 9.Орчны өөрчлөлтөд дасах 10. Хүмүүсийн хоорондох ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэлтэй хандах 11. Оролдлоготой, санаачилгатай, тууштай байх 12. Дүрэм журмыг ойлгох, мөрдөх гэж тусгажээ.

- Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 3 настай хүүхдийн 89.3 хувь өөрийгөө бүтэн нэрээрээ танилцуулдаг, бүсээр авч үзэхэд тэдний 95.8 хувь, өөрийн нэрээ бүтэн хэлж танилцуулсан байна.
- Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй 3 настай хүүхдийн 22.6 хувь, 5 настай хүүхдийн 2.4 хувь нь насаа хуруугаараа харуулсан байна.
- Судалгаанд хамрагдсан 3 настай хүүхдийн 78.6 хувь нь хүйсээ зөв танилцуулсан, 5 настай хүүхдийн 98.8 хувь нь хүйсийн тухай ойлголттой болсон байна.
- Аав,ээжийнхээ нэрийг хүүхдүүд 3 наснаас хэлж эхэлдэг ба аавынхаа нэрийг илүү сайн хэлж чаддаг байна.
- Гурав, дөрвөн настай хүүхдүүд ам бүлийнхээ тоог хэлхээс илүү аав ээж, ах, дүүтэйгээ амьдардаг гэж тоочиж нэрлэдэг байна.
- Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдүүд суралцаж буй бүлгийн нэрээ цөөн хувь нь хэлж танилцуулсан байна.
- Хүүхдүүд 3 насандаа өөрийнхөө хүйс, нэр, ээж аавынхаа нэрийг болон өөрийн суралцаж буй бүлэг, гэр бүлийн гишүүдийн тухай ойлголттой болсон байдаг байна.
- Хүүхдүүд 3 насандаа өөрийн насаа зөв хэлэх, ам бүлийн тоогоо хэлэх, суралцаж буй бүлгийнхээ нэрийг мэдэх хэлэх нь бүс тус бүрд ялгаатай хүйс, нэрээ мэдэх чадвараас сул байгаа тул сургалтаар дэмжих шаардлагатай байна.
- Судалгаанд хамрагдсан хүүхдийн 72.6 хувь нь эерэг сэтгэлийн хөдөлгөөнөө ямар үед хэрхэн илэрч байсан талаар өгүүлсэн байна. Хүүхдийн нас нэмэгдэх тусам ямар сэтгэл хөдлөл ямар үед үүсдэг тухай мэддэг, ялгаж тайлбарладаг болдог байна.
- Хүүхдийн 31.3 хувь яагаад ууртай, гунигтай болдог талаар тодорхой хариулт өгч чадаагүй байна. Хүүхдийн өөрийн сөрөг сэтгэл хөдлөлийг таньж мэдэх чадвар нас нэмэгдэх тусам сайжирдаг байна.
- Хүүхэд өөрийн сэтгэл хөдлөлийг илэрхийлж таньж байгаа байдлыг авч үзэхэд 3 настай хойд бүсийн хүүхдүүд эерэг, сөрөг сэтгэл хөдлөлөө илэрхийлэх байдал маш сул байна. Урд болон төвийн бүсийн хүүхдүүд сөрөг сэтгэл хөдлөлийг илэрхийлэх байдал сул байна.
- Хүүхдүүд бие биенийхээ бие биенийхээ нүүрний хувирал, биеийн хөдөлгөөнийг харж ямар сэтгэлийн хөдөлгөөнтэй байгааг ялгаж чаддаг байна.
- Хүүхдүүд 3 наснаас бие биенийхээ нүүрний хувирал, биеийн хөдөлгөөнөөс харж ямар сэтгэлийн хөдөлгөөнтэй байгааг ялгаж таних нь ууртай байгаа баярлаж байгаа нүүр царайны илрэлийг таних боломжтой болдог байна.
- СӨБ -д суралцаж буй 3 насны хүүхдийн 86.9 хувь нь үе тэнгийнхэнтэйгээ найзлан тоглох болж нас нэмэгдэх тусам энэ чадвар сайжирдаг байна.
- Хүүхдээс найзуутайгаа хэрхэн тоглодог талаар асуухад 3 настай хүүхдийн 2.4 хувь нь хамтран тоглодоггүй, 4,5 настай хүүхдийн 1.2 хувь нь хамтран тоглодоггүй ганцаараа тоглодог гэсэн бол нийт хүүхдийн 95.6 хувь нь найзуудтайгаа хэрхэн тоглодог тухайгаа тайлбарлан ярьсан байна.

- Хүүхдүүд тоглоомоо найзуудтайгаа хувааж тоглох талаарх ойлголт 3 наснаас бий болдог байна. Гурван настай хүүхдийн 13.3 хувь нь ганцаараа тоглоомоороо тоглох дуртай гэсэн бол найддаа тоглоомоо өгнө, хамт тоглоно гэж 47.6 хувь нь хариулсан байна.
- Яаралтай аюултай зүйл тохиолдсон үед хамгийн ойр байгаа хэн нэгнээс тусламж хүсэх тухай ойлголттой болгох хэрэгтэй байна.
- Хэрэгцээтэй зүйлээ авах гэж аав ээж гэх мэт гэр бүлийн гишүүдээс л тусламж авна гэж 3 настай хүүхдийн 36.9 хувь хариулсан бол нас нэмэгдэх тусам сайжирдаг байна.
- Судалгаанд хамрагдсан 4 настай хүүхдүүд зөвхөн ойр дотны таньдаг хүнээсээ тусламж авна гэж хариулсан байна.
- Судалгаанд хамрагдсан 5 настай хүүхдүүд өмнөх насны хүүхдийг бодвол ойр дотны болон яаралтай үед хажууд ойрон байгаа хүнээс тусламж гуйна гэж хариулсан байна.
- Хүүхдүүд хог хаях нь ямар хортой талаар учир шалтгааныг тайлбарласан хариултуудыг эрэмблэн авч үзвэл орчноо бохирдуулна, гэрээ муухай болгоно, байгаль, дэлхийгээ муухай болгоно гэсэн хариултууд давамгайл байна.
- Олон нийтийн газар уйлах нь зөв гэж 3 настай хүүхдийн 11.9 хувь нь хариулсанаас өөрийн санал сэтгэл хөдлөлийг хүүхдүүд хаана яаж гаргах талаар тодорхой мэдлэгтэй болсон байдаг байна.
- Хүүхдүүдийн дүрэм журам баримтлах чадварыг авч үзэхэд зөв буруу гэж хариулсан хариултынхаа шалтгааныг 3 насны хүүхдийн 36.9 хувь тайлбарлаагүй бол 23.8 хувь дутуу тайлбарласан, 77.4 хувь нь яагаад тэгэх ёстой шалтгааныг тайлбарласан байна

1.4. ДҮГНЭЛТ

Хүүхдийн амьдралын орчин

- Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн нас, хүйсийн харьцаа тэнцвэртэй, төлөөлөх чадвартай байна.
- Хүүхдүүдийн 88.9 хувь нь гэртээ, 11.1 хувь нь эмээ, өвөөгийн дээ амьдардаг байна.
- Өрхийн гишүүдийн тоо дунджаар 4–5 бөгөөд цэцэрлэгт хүрэх зай 500 м–1 км орчим байна.

Эцэг эхийн ажил эрхлэлт ба боловсрол

- Судалгаа 1 тэй харьцуулахад эцэг эхийн төсвийн байгууллагад ажиллах хувь нэмэгдсэн нь тогтвортой орлоготой, боловсролтой эцэг эхийн тоо өсч байгааг илэрхийлж байна.
- Эцэг эхийн дээд боловсрол эзэмшилт нэмэгдэж, боловсрол эзэмшээгүй хувь буурсан нь хүүхдийн хөгжлийг дэмжих боломжтой болж байна.
- Малчин эцэг эхийн хувь зүүн, урд бүсэд өндөр байгаа нь бүсийн ялгаатай байгааг илэрхийлж байна.

Өрхийн орлого

- Өрхийн сарын орлого 5 жилийн өмнөх үеэс амьжиргааны түвшин болон боловсролын түвшин ажил эрхлэлт нэмэгдсэн байгааг харуулна.
- Төвийн бүсийн хүүхдүүдийн 71.3 хувь нь хамгийн өндөр орлоготой өрхөд амьдарч байна. Бүсийн хувьд өрхийн орлого харилцан адилгүй байна.

Эцэг эхийн оролцоо ба хүүхдийн хөгжлийн дэмжлэг

- Эцэг эхийн 90.1 хувь нь хүүхдэдээ ном уншиж өгдөг, ялангуяа зүүн, баруун, урд бүсийн эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо өндөр байна.
- СӨБ-ын сургалтыг дэмжих урлаг, бүжиг, гимнастик, бусад үйл ажиллагаанд хүүхдүүдийг оролцуулж байгаа нь хүүхдийн оролцоог хангах оролдлого байгааг харуулна.
- Эцэг эхийн үнэлгээгээр хүүхдүүд бие даан үйлдэл хийх, сонирхсон зүйлээ дуустал гүйцэтгэх, жижиг булчингийн хөдөлгөөн хийх чадвар сайжирсан байна.

Хөдөлгөөн, дүрэм журам, дадал зуршил

- Хүүхдүүдийн хөдөлгөөний чадвар, дүрэм журам баримтлах хандлага өмнөх судалгаагаар харьцуулахад сайжирсан байна.
- Хүүхдүүдийн 84.9 хувь нь хог хаях дүрмийг баримталдаг, 35.7 хувь нь дэлгүүрт дуртай зүйлээ авахын тулд хааяа уйлдаг нь ёс суртахууны төлөвшил, нийгмийн орчинд хариу үйлдэл үзүүлэх чадвар хөгжиж байгааг харуулна.

Танин мэдэхүйн хөгжлийн нэгдсэн дүгнэлт

Мэдээлэл хүлээн авах чадвар

- Ажиглах чадвар 3–5 насанд сул, ялангуяа 3 настай хүүхдүүдийн 81 хувь нь “маш хангалтгүй” түвшинд байна.
- Анхаарлын тогтворжилт нас ахих тусам мэдэгдэхүйц сайжирч, 5 настай хүүхдүүдийн 70.2 хувь нь “маш өндөр” түвшинд гүйцэтгэлтэй байна.
- Харааны ой тогтоолт, анхаарлын шилжилт 3 настай хүүхдүүдэд харьцангуй сайн байна.
- Сонсож тогтоох чадвар хүүхдүүд эхний, дунд, сүүлчийн үгсийг илүү сайн тогтоож, дундах үгсийг сул тогтоодог байна.

Бүсийн ялгаа:

Бүс	Ажиглах чадвар	Анхаарал	Сонсож тогтоох
Төв	5 насанд 30.6 хувь “өндөр”	Сайжирч байгаа	4–5 насанд хамгийн сайн
Хойд	3–4 насанд маш сул	4–5 насанд сайн	Дэмжих шаардлагатай
Урд	3 насанд маш сул	3–4 насанд дэмжих	4 насанд 91.6 хувь нь хангалтгүй
Зүүн	3 насанд 41.7 хувь маш сул	4–5 насанд сайн	5 насанд 75 хувь нь хангалтгүй
Баруун	Сонсож тогтоох чадвар сайн	3–4 насанд дэмжих	Ой тогтоолт сул (4 насанд 25 хувь)

Сэтгэхүй

- Логик сэтгэх чадвар нас ахих тусам тогтвортой сайжирч, 5 настай хүүхдүүдийн 96.5 хувь нь “өндөр” түвшинд гүйцэтгэлтэй.
- Харьцуулан ангилал чадвар 5 насанд 53.5 хувь өссөн.
- Нэгтгэн дүгнэх чадвар нас ахих тусам сайжирч, бүс бүрт “өндөр” түвшинд хүрч байна.

Бүсийн онцлог:

- Төвийн бүс: 5 настай хүүхдүүдийн логик сэтгэх чадвар “маш өндөр” – 94.4 хувь
- Хойд бүс: 5 настай хүүхдүүдийн логик сэтгэх чадвар “маш өндөр” – 8.3 хувь дэмжих шаардлагатай

Хэл ярианы чадвар

- Зураг харж санаагаа илэрхийлэх чадвар нас ахих тусам өгүүлбэрийн тоо, үгийн хэрэглээ нэмэгдэж байна.
 - 5 настай хүүхдүүдийн 15.5 хувь нь 7 өгүүлбэрээр санаагаа илэрхийлсэн.
 - 41–55 үг ашигласан хүүхэд 6.8 хувь байна.
- Судалгааны хооронд идэвхтэй үг, өгүүлбэрийн тоо нэмэгдсэн нь хэл ярианы хөгжлийн эерэг хандлагыг харуулж байна.

Бүсийн онцлог:

- Төвийн бүс: Хэл ярианы гүйцэтгэл хамгийн сайн
- Хойд бүс: Хэл ярианы гүйцэтгэл сул → дэмжих шаардлагатай
- Зүүн, баруун, урд бүс: Нас ахих тусам тогтвортой өсөлттэй

Танин мэдэхүйн чадварууд (ажиглах, анхаарал, ой тогтоолт, сэтгэхүй, хэл яриа) нас ахих тусам мэдэгдэхүйц сайжирч байна.

- Хойд, зүүн, урд бүсийн хүүхдүүдийн ажиглах, сонсох, логиктой сэтгэх чадвар сул байгаа тул сургалтаар дэмжих

СӨБ-ын хөтөлбөрт тусгасан танин мэдэхүйн суурь чадамжууд хүүхдүүдэд төлөвшиж байгаа ч зарим чадварыг онцгойлон дэмжих шаардлагатай байна.

Нийгэмшлийн чадварын нэгдсэн дүгнэлт

Өөрийгөө танин мэдэх, илэрхийлэх чадвар

- Хүүхдүүд 3 наснаас эхлэн нэр, хүйс, нас, ээж аавын нэр, бүлгийн нэр, гэр бүлийн гишүүдийн тухай ойлголттой болж эхэлдэг.

- Нас ахих тусам эдгээр чадварууд сайжирч, 5 настай хүүхдүүдийн дийлэнх нь өөрийгөө бүрэн танилцуулж, мэдээллээ зөв илэрхийлж чаддаг.
- Гэсэн хэдий ч ам бүлийн тоо, бүлгийн нэр, насны илэрхийлэл зэрэг зарим ойлголт 3 настай хүүхдүүдэд сул байгаа нь сургалтаар дэмжих шаардлагатайг харуулж байна.

Сэтгэл хөдлөлийг таних, илэрхийлэх, зохицуулах чадвар

- Хүүхдүүд эерэг, сөрөг сэтгэл хөдлөлийг таньж, илэрхийлэх чадвартай болж байгаа ч бүс нутгийн ялгаа ажиглагдаж байна.
 - Хойд бүсийн 3 настай хүүхдүүдийн сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар хамгийн сул байна.
 - Урд болон төвийн бүсийн хүүхдүүд сөрөг сэтгэл хөдлөлийг илэрхийлэх тал дээр дэмжлэг шаардлагатай.
- Нас ахих тусам хүүхдүүд сэтгэл хөдлөлийн шалтгаан, нөхцөл байдлыг тайлбарлах чадвартай болж, сэтгэл хөдлөлийн зохицуулалт сайжирдаг.

Харилцааны чадвар

- Үе тэнгийнхэнтэйгээ найзлан тоглох, хамтран тоглох, тоглоомоо хуваалцах ойлголт 3 наснаас эхлэн төлөвшдөг.
- 95.6 хувь хүүхэд найзуудтайгаа хэрхэн тоглодог тухайгаа тайлбарлаж чадсан нь харилцааны эерэг хандлага төлөвшиж байгааг харуулж байна.
- Гэсэн хэдий ч ганцаараа тоглох дуртай, хамтран тоглохгүй хандлагатай хүүхдүүд цөөнгүй байгаа нь нийгэмшлийн дэмжлэг шаардлагатай байж болно.

Тусламж хүсэх, нийгмийн орчинд хариу үйлдэл үзүүлэх чадвар

- Хүүхдүүд ойр дотны хүнээс тусламж хүсэх хандлагатай бөгөөд 5 настай хүүхдүүд яаралтай үед ойр байгаа хүнээс тусламж гуйх ойлголттой болсон.
- Гэсэн хэдий ч 3 настай хүүхдүүдийн 10.7 хувь нь хэрхэн тусламж хүсэхээ мэдэхгүй байгаа нь аюултай нөхцөлд хариу үйлдэл үзүүлэх чадвар сул байгааг харуулж байна.

Дүрэм журам баримтлах ойлголт

- Хүүхдүүд хог хаях, олон нийтийн газар уйлах, дүрэм журам баримтлах талаарх ойлголттой болж байна.
- 96.4 хувь нь хогоо заавал хогийн саванд хаях ёстой гэж үзсэн нь байгаль хамгаалах талаарх ойлголттой болж байна.
- Дүрэм журмын талаар буруу, зөв гэж хариулсан хүүхдүүдийн 77.4 хувь нь шалтгааныг тайлбарласан нь логик сэтгэлгээ хөгжиж байгааг илэрхийлнэ.

Хүүхдийн нийгэмшлийн чадварууд нас ахих тусам тодорхой, тогтвортой сайжирч байна.

- Бүс нутгийн ялгаа тодорхой ажиглагдаж байгаа тул бүс тус бүрд чиглэсэн сургалтын дэмжлэг шаардлагатай.
- Сэтгэл хөдлөлийн зохицуулалт, тусламж хүсэх чадвар, дүрэм журам баримтлах ойлголт нь хүүхдийн нийгэмшлийн төлөвшлийн гол үзүүлэлт болж байна.
- СӨБ-ын хөтөлбөрт тусгасан 12 чадварын ихэнх нь 3–5 насны хүүхдүүдэд төлөвшиж эхэлсэн ч зарим чадваруудыг зорилтот сургалтаар дэмжих шаардлагатай байна.

Бие бялдын хөгжлийн нэгдсэн дүгнэлт

Биеийн өсөлт ба бүс нутгийн ялгаа

- Хүүхдийн биеийн өсөлт физиологийн хөгжлийн дагуу нас ахих тусам сайжирч байгаа ч бүс нутгийн ялгаа тод ажиглагдаж байна.
 - Төвийн бүсийн хөвгүүд хамгийн өндөр үзүүлэлттэй.
 - Зүүн бүсийн хөвгүүд хамгийн бага үзүүлэлттэй бөгөөд гимнастикийн оролцоо дутмаг байгаатай холбоотой байж болзошгүй.
 - Хойд бүсийн хүүхдүүдийн стандарт хазайлт өндөр байгаа нь өсөлтийн ялгаа ихтэйг илтгэнэ.

Насны онцлог ба өсөлтийн хурдац

- Хөвгүүдийн хувьд 4 насанд биеийн өндөр мэдэгдэхүйц өссөн, харин 3 болон 5 насанд тогтвортой буюу бага зэрэг буурсан байна.

- Охидын хувьд 3 насанд өндөр буурсан, 4 насанд тогтвортой, 5 насанд багассан үзүүлэлттэй байна.
- Энэ нь өсөлтийн хурдац насны онцлогоос хамаарч харилцан адилгүй явагдаж байгааг харуулна.

3. Бие бялдрын чадваруудын төлөв

Чадвар	Насны хандлага	Хүйсийн ялгаа	Бүсийн онцлог
Хурд	Нас ахих тусам сайжирсан	Баруун бүсийн охид хамгийн хурдан	Хөвгүүдийн гүйцэтгэл тогтмол бус
Уян хатан	Тогтвортой өсөлттэй	Охид илүү гүйцэтгэлтэй	Бүсийн ялгаа бага
Тэнцвэр	Огцом сайжирсан	Судалгаанаас хамаарч өөрчлөгдөнө	
Хөлийн хүч	Нас ахих тусам сайжирсан	Хөвгүүд илүү гүйцэтгэлтэй	Бүсийн ялгаа ажиглагдана
Тэсвэр	5 насанд илүү сайжирна	Хөвгүүд давуу гүйцэтгэлтэй	Бүсийн ялгаа тодорхойгүй

СӨБ-ын хөтөлбөртэй уялдаа

- Монгол Улсын СӨБ-ын цөм хөтөлбөрт “Биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал” суурь чадамжид:
 - Хөдөлгөөний эв дүй, хурд хүч, уян хатан, тэсвэр, тэнцвэрийг сайжруулах дасгал, тоглоомд идэвхтэй оролцохыг тусгасан.
- “Хөдөлгөөн, эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрэх үр дүн нь:
 - Хүүхэд алхах, гүйх, үсрэх, тэнцвэрээ хадгалах, зүг чигээ баримжаалах чадвартай болох.
 - Хариу үйлдэл шаардсан хөдөлгөөнт тоглоомд дүрмийн дагуу оролцох, зааврын дагуу зөв гүйцэтгэх чадвар эзэмших.